

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр, Лхагва гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 83
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	84 – 186
1.	<i>Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	85 – 99
2.	<i>Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/</i>	99 – 186

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 11 дүгээр сарын 05-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 62.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 33 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Чөлөөтэй: З.Мэндсайхан, Б.Түвшин;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Булгантуяа;
Тасалсан: Ц.Даваасүрэн, Ч.Номин, Г.Тэмүүлэн.*

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсжаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, С.Төрмөнх нар байлцав.

Төсвийн байнгын хорооны 2025 оны 22 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгээс Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар гаргасан танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

**Нэг.НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Х.Ганхуяг: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, М.Бадамсүрэн, Ц.Баатархүү, Ж.Баясгалан, Б.Бейсен, Г.Лувсанжамц, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа, Д.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 17¹ дүгээр зүйл нэмэх:

“17¹ дүгээр зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

17¹.1.Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1.а дахь дэд заалтыг 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал дагаж мөрдөнө.

17¹.2.Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1.б дэх дэд заалтыг 2027 оны төсвийн жилээс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 7
Бүгд: 22

68.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Х.Ганхуяг: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 15.2.1.а дахь дэд заалтын “2026 оны татварын жилд” гэснийг, 15.2.1.б дэх дэд заалтын “2027 оны татварын жилээс эхлэн” гэснийг “албан татвар төлөгчийн албан татвар суутган төлөгчтэй хийсэн” гэж, “1 дүгээр зүйл” гэснийг “2 дугаар зүйл” гэж, “2 дугаар зүйл” гэснийг “3 дугаар зүйл” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 5

Бүгд: 22

77.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “01 дүгээр” гэснийг “10 дугаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 5

Бүгд: 22

77.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Саналын томьёололын 1 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэрийн “ӨӨРЧЛӨЛТ” гэсний өмнө “НЭМЭЛТ,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 5

Бүгд: 22

77.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**Хоёр.ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ
САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:**

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Х.Ганхуяг: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 18.4 дэх хэсгийн “хийж болно.” гэснийг “хийнэ.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 14

Бүгд: 22

36.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшиний гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 19
Бүгд: 22
13.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

3.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 20
Бүгд: 22
9.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 8 дахь заалтын 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.1.7 дахь заалт нэмэх:

“25.1.7.нийгмийн нөлөөллийн шинжилгээний санал, дүгнэлт;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 20
Бүгд: 22
9.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

-Төслийн 3 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “8.1.3 дахь заалтын “Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, Засгийн газраар хэлэлцүүлэх зөвшөөрлийг авах” гэснийг “Төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтийг авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлэх” гэж, мөн зүйлийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 6

Бүгд: 23

73.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 4 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

-Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

6.Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшиний гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “заалт, 17 дугаар зүйлийн 17.1.2.6 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.4.2 дахь” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2

Татгалзсан: 20

Бүгд: 24

8.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

-Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 6 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**Гурав. “ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС ГАРГАХ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:**

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Х.Ганхуяг: 1. Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3-Т” гэснийг “12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3, 12.1.5-д” гэж, мөн заалтын “мөн зүйлийн 12.1.4-Т” гэснийг “мөн зүйлийн 12.1.4, 12.1.5-д” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	16
Бүгд:	24

33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

**Дөрөв. “ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ
ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:**

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Үүрийнтуяа нар үг хэлэв.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Х.Ганхуяг: 1. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах” гэснийг “Монгол Улсын Үндсэн хуульд заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх, түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдох зарчмын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 6
Бүгд: 25
76.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дахь дэд заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 4
Бүгд: 25
84.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дахь дэд заалтыг доор дурдснаар өөрчлөн найруулах:

“3/Энэ тогтоолын 1 дэх дэд заалтыг хэрэгжүүлэхдээ хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах, бүтээгдэхүүн арилжаалах зэрэг бүхий л үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод нээлттэй, үр ашигтай зохион байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 6
Бүгд: 25
76.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн санал дэмжигдсэн тул Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 5 дахь дэд заалт нэмэх:

“5/Тавантолгойн бүлэг ордтой холбоотойгоор байгуулсан, хэрэгжүүлсэн төрийн нууцад авсан гэрээ, хэлцэл, тэдгээрийг байгуулахыг зөвшөөрсөн, дэмжсэн төрийн нууцад авсан холбогдох бүх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу төрийн нууцаас гаргах арга хэмжээг 2026 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор авч хэрэгжүүлж, Монгол Улсын Их Хуралд тайлагнах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 14
Бүгд: 25
44.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаан 13 цаг 13 минутаас 15 цаг 45 минутад завсарлав.

Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Дашпүрэв, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсжаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Баттуяа, мөн газрын Санхүүгийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, С.Төрмөнх, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албаны дарга Д.Эрдэнэсамбуу, референт Д.Гэрэлт-Од, ахлах мэргэжилтэн Б.Одмандах нар байлцав.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 онд төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 онд төсвийн тухай хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцад тусгагдсан урсгал болон хөрөнгө оруулалтын зардалд зохицуулалт хийх санал.

Х.Ганхуяг: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Д.Батбаяр, Ж.Алдаржавхлан, Р.Батболд, Б.Заяабал, Д.Жаргалсайхан, Х.Жангабыл, П.Мөнхтулга, Г.Тэмүүлэн. /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, **Зардал бууруулах санал:**

1.1.Урсгал зардал бууруулах:

- Төрийн албан хаагчдын цалин хөлс, Хүүхдийн мөнгөн тэтгэмж, Нийгмийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Боловсролын салбарын гүйцэтгэлийн санхүүжилт, улсын төсвөөс санхүүжих эрүүл мэнд, боловсролын байгууллагууд, гамшиг, ослоос хамгаалах, эрэн хайх, аврах ажиллагааны зардал, Засгийн газрын зээлийн үйлчилгээний хүүгийн зардал, гадаад зээл, тусламжаас санхүүжих урсгал зардал, 100 хувь өөрийн орлогоос санхүүжих зардлыг хөндөхгүйгээр аймгуудын урсгал зардлыг **6.0 хувиар**, бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлыг **12.8 хувиар** бууруулж, нийт **411,447.6 сая** төгрөгөөр;
- Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “**1,542,428.4**” гэснийг “**1,235,328.4**” гэж холбогдох шийдвэрийн хамт өөрчлөн, гадаад зээллэгийн ашиглалтыг **307,100.0 сая** төгрөгөөр;
- Улсын Их Хурлын гишүүдийн зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг **88.9 сая** төгрөгөөр;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын “Эрчим хүчний экспортыг дэмжих нэгж”-ийн урсгал зардлыг **2,588.6 сая** төгрөгөөр;
- Ойн газрын урсгал зардалд ойжуулалтын зардалд зориулж **44,161.7 сая** төгрөг тусгагдсан тул Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны урсгал зардалд давхар тусгагдсан ойжуулалтын хөтөлбөрийн зардлыг **5,023.5 сая** төгрөгөөр;

- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын төсвийн багцын аялал жуулчлалын чиглэлийн хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасыг **8,000.0 сая** төгрөгөөр;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцын “Шинэ хоршоо хөтөлбөр”-ийн 2026 оноос шинээр олгохоор тооцсон зээлийн хүүгийн татаасыг **22,000.0 сая** төгрөгөөр;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцын Зээлийн батлан даалтын сангийн дүрмийн санг нэмэгдүүлэхэд тусгагдсан санхүүжилтийг **25,000.0 сая** төгрөгөөр;
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн санхүүжилтийг **10,000.0 сая** төгрөгөөр;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын төрийн албан хаагчийг мэргэшүүлэх зардалд зориулж Удирдлагын академид олгодог санхүүжилтийг **4,636.6 сая** төгрөгөөр;
- 2026 оны төсвийн жилд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шадар сайд нарын ажлын алба болон бүх яамдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардал шинээр тусгагдсаныг хасаж, нийт **10,000.0 сая** төгрөгөөр;
- Хархорум хотын Захирагчийн ажлын албаны урсгал зардлыг 2025 оны түвшинд тооцож **2,840.0 сая** төгрөгөөр;
- Орон нутгаас бусад бүх төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал засварын зардлыг **40,000.0 сая** төгрөгөөр;
- Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын их засварын зардлыг төсвийн шатлал хоорондын тооцооллыг оруулснаар тооцож **40,000.0 сая** төгрөгөөр;
- Үндэсний аудитын газрын урсгал зардлыг 2025 оны түвшинд тооцож **4,916.8 сая** төгрөгөөр;
- Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын эрдэм, шинжилгээ судалгааны ажлын зардлыг **916.8 сая** төгрөгөөр;
- Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцын судалгаа шинжилгээний зардлыг **1,510.2 сая** төгрөгөөр;
- Шадар сайдын төсвийн багцын эрдэм шинжилгээ, судалгааны зардлыг **9,000.0 сая** төгрөгөөр;
- Орон нутгийн авто замын сангийн санхүүжилтийг төсвийн шатлал хоорондын харилцаагаар тооцсон дүнгээр буюу **60,000.0 сая** төгрөгөөр;
- Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Улсын ерөнхий прокурор болон Шадар сайдаас бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардлыг 2025 оны түвшинд тооцож нийт **6,816.7 сая** төгрөгөөр буюу нийт **971,885.7 сая** төгрөгөөр бууруулах.

1.2.Хөрөнгийн зардал бууруулах:

- Төслийн 2 дугаар хавсралтын Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцийн 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой болон боловсрол, эрүүл мэнд, онцгой байдал, батлан хамгаалах, соёл, улсын бүртгэл, шүүх шинжилгээ, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн

байгууллага, сонгуулийн тоног төхөөрөмжөөс бусад шинээр хэрэгжүүлэх тоног төхөөрөмжийн санхүүжилтийг **50 хувиар** буюу **62,930.4 сая** төгрөгөөр, 2026 онд дуусах хөрөнгө оруулалтын төслүүдийг хөндөхгүйгээр, 2027 он болон түүнээс цааших онуудад шилжих хөрөнгө оруулалтын төслүүдийн 2026 онд санхүүжих дүнг зам тээврийн салбарынхыг **17.2 хувиар** буюу **77,367.8 сая** төгрөгөөр, бусад салбарынхыг **15 хувиар** буюу **127,010.7 сая** төгрөгөөр, УТ2601300905 төслийн кодтой “Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцийн 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой барилга байгууламж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **150,000.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацааг 2026-2027 он гэж өөрчлөн, 2026 онд санхүүжих дүнг **50,000.0 сая** төгрөгөөр, уг саналуудад давхардаагүй Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлж нийт **14,529.3 сая** төгрөгөөр **Хавсралт 1-д** тусгагдсаны дагуу нийт **331,838.2 сая** төгрөгөөр бууруулах.

2.Зардал нэмэгдүүлэх санал:

2.1.Урсгал зардал нэмэгдүүлэх санал:

- Боловсролын салбарын гүйцэтгэлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх хүрээнд багш нарын үндсэн цалинг 2026 оны 01 дүгээр сарын 01-ээс **742.0 мянган** төгрөгөөр, 11 дүгээр сарын 01-ээс **2,800.0 мянган** төгрөгт хүргэхээр тооцож Боловсролын сайдын урсгал зардлыг **518,620.2 сая** төгрөгөөр;
- Эмч, эмнэлгийн байгууллагын ажиллагсдын цалинг **15 хувиар** нэмэгдүүлэхэд зориулж Эрүүл мэндийн сайдын урсгал зардлыг **190,300.0 сая** төгрөгөөр;
- Төрийн өмчийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ажилчдын цалинг **15 хувиар** нэмэгдүүлэхэд зориулж Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын урсгал зардлыг **9,794.9 сая** төгрөгөөр, Боловсролын сайдын урсгал зардлыг **925.7 сая** төгрөгөөр, нийт **10,720.6 сая** төгрөгөөр;
- Ахмад настны тэтгэврийг 6 хувиар нэмэгдүүлэхээр төсөлд тусгагдсаныг инфляцын түвшинтэй уялдуулан тооцож **8.6 хувь** болгон нэмэгдүүлэхэд зориулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын урсгал зардлыг **145,000.0 сая** төгрөгөөр;
- Халамжийн тэтгэврийг 6 хувиар нэмэгдүүлэхээр төсөлд тусгагдсаныг инфляцын түвшинтэй уялдуулж тооцож **8.6 хувь** хувь болгон нэмэгдүүлэхэд зориулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын урсгал зардлыг **19,500.0 сая** төгрөгөөр;
- Монгол Улсын иргэний дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүүхэд залуучуудын суралцах тэгш боломжийг хангах, дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцахад дэмжлэг үзүүлэх зорилгоор

олгодог “Илгээлт-2100” хөтөлбөрийн санхүүжилтийг **33,000.0 сая** төгрөгөөр;

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын урсгал зардлыг **2,446.8 сая** төгрөгөөр;
- Хүний эрхийн сурах бичигт зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг **231.9 сая** төгрөгөөр;
- Шатахууны нөөцийн агуулах, дэд бүтэц бүрдүүлэх хүүгийн татаас, хяналтын системийг бүрдүүлэх зардалд **20,000.0 сая** төгрөгөөр буюу нийт **939,819.5 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.Хөрөнгийн зардал нэмэгдүүлэх санал:

- Магадлалын ерөнхий дүгнэлтэд хийсэн аудитын дүгнэлтийг үндэслэж хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэхтэй холбогдуулан эрүүл мэнд, боловсролын салбарын зарим төсөл, арга хэмжээг төсөлд шинээр тусгах, санхүүжих дүнг нэмэгдүүлэх мөн Хөгжлийн бодлогын зарим баримт бичгүүд, бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгагдсан авто зам, гүүр, эрчим хүч, иргэдийн орон нутагтаа ажиллаж, амьдрах, бизнес эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлсэн өрсөлдөх чадвартай бүсүүдийг бий болгох зорилт, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор хөрөнгийн зардлыг **363,904.4 сая** төгрөгөөр буюу **Хавсралт 2-т** тусгагдсаны дагуу нэмэх.

3.Орлого нэмэгдүүлэх санал:

Татварын зарлагыг бууруулах буюу нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжих хугацааг хойшлуулж, үүнтэй уялдуулан татварын орлогыг **375,000.0 сая** төгрөгөөр, мөн төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг 2025 оны төсөвлөсөн дүнд хүргэж **5,000.0 сая** төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх.

4.Орлого бууруулах санал:

Агаарын навигацын үйлчилгээний хураамжийн орлогоос төсөвт төвлөрүүлэхээр тооцсон дүнг **40,000.0 сая** төгрөгөөр, мөн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогыг **10,000.0 сая** төгрөгөөр тус тус бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 11

Бүгд: 26

57.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Төсвийн тэнцэлд нөлөөлөхгүй зохицуулалтын санал.

Х.Ганхуяг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601100108 төслийн кодтой “Татварын мэдээллийн системийн дэд бүтэц, серверийн болон татварын албадын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **23,026.9 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **19,706.6 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр төслийн 2 дугаар хавсралтад “Чойбалсан нисэх буудал /Аэродром/-ын хөөрч, буух зурвас, шинэчлэх /Дорнод, Хэрлэн сум/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг **59,120.0 сая** төгрөг, санхүүжих дүн **19,706.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмэх гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 13
Бүгд: 26
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 11
Бүгд: 26
57.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Х.Ганхуяг: Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601100108 төслийн кодтой “Татварын мэдээллийн системийн дэд бүтэц, серверийн болон татварын албадын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **23,026.9 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **19,706.6 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр төслийн 2 дугаар хавсралтад “Чойбалсан нисэх буудал /Аэродром/-ын хөөрч, буух зурвас, шинэчлэх /Дорнод, Хэрлэн сум/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг **59,120.0 сая** төгрөг, санхүүжих дүн **19,706.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмэх гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 10
Бүгд: 26
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/”,

хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **40,000.0** сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **3,068.7 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Цэцэрлэгийн барилга 150 ор /Дорнод, Дашбалбар сум/”, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **6,137.4 сая** төгрөг, санхүүжих дүн **3,068.7 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 8

Бүгд: 26

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **40,000.0** сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **2,231.9 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Цэцэрлэгийн барилга 150 ор /Дорнод, Матад сум/”, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **4,463.6 сая** төгрөг, санхүүжих дүн **2,231.9 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 9

Бүгд: 26

65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2102900758 төслийн кодтой “Гандангийн дэнж” шинэ аялал жуулчлалын бүсийн зураг төсөв, барилгын ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо/”, хэрэгжих хугацаа 2022-2027 он, төсөвт өртөг **23,484.9 сая** төгрөг, санхүүжих дүн **6,130.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **3,090.0 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Хүүхэд залуучуудын “Зүүн наран” хүрээлэн /Улаанбаатар, Баянгол дүүрэг/”, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **9,271.9 сая** төгрөг, санхүүжих дүн **3,090.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 8

Бүгд: 26

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804408 төслийн кодтой “Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7 км /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/”, хэрэгжих хугацаа 2024-2027 он,

төсөвт өртөг **186,000.6 сая** төгрөг, санхүүжих дүн **40,000.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **1,719.0 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Монголын товчоо цогцолборын барилгын гадна тохижилтийн ажлын нэмэлт ажил /Хэнтий, Дэлгэрхаан сум/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **685.0 сая** төгрөг”, “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Баян-Овоо сум/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн **434.1 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, “Уурын зуухны барилгын шугам сүлжээний засвар /Хэнтий, Мөрөн сум/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **600.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 9

Бүгд: 26

65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/”, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг **202,137.9 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **23,950.1 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **4,080.2 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Баян-Адрага сум/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн **404.3 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Бэрх тосгон/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн **651.8 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, “Шихихутаг, нууц товчоо түүхэн аялал жуулчлалын барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Норовлин сум/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **641.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, “Их хуралдай цогцолборын барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Биндэр сум/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **238.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, “Соёлын төвийн барилга, /Хэнтий, Батширээт сум/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **436.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, “Соёлын төвийн барилга, /Хэнтий Цэнхэрмандал сум/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **1,707.9 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 9

Бүгд: 26

65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800893 төслийн кодтой Замын-Үүд талаас Сайншанд чиглэлийн 16 км хатуу хучилттай

замын хэсэгчилсэн их засвар /Дорноговь/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **22,268.3 сая** төгрөг, санхүүжих дүн **10,020.8 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасаж, энэ эх үүсвэрээр “Саран хөхөө дуулалт театр төсөвт өртөг **15,800.0 сая** төгрөг, санхүүжих дүн **8,300.3 сая** төгрөг төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 9

Бүгд: 26

65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2003400774 төслийн кодтой “Байгалийн түүхийн музейн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/, хэрэгжих хугацаа 2020-2026 он, төсөвт өртөг **130,618.4 сая** төгрөг, санхүүжих дүн **51,982.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг аудитын магадлалын ерөнхий дүгнэлтийг үндэслэн **94,691.1 сая** төгрөгөөр нэмэгдүүлж, санхүүжих дүнг **36,000.0 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Байгалийн түүхийн музейн үзүүлэг дэглэлт, үзмэрийн интерьерийн зураг, цуглуулга, үзмэрийн тоноглол, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Хан-Уул/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **178,368.0 сая** төгрөг, санхүүжих дүн **36,000.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 10

Бүгд: 26

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцад тусгагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Цөлжилттэй тэмцэх тухай” суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлын үед зохиогдох соёл, урлагийн арга хэмжээний зардлыг **4,000.0 сая** төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын багцын Кино урлагийг дэмжих сангийн санхүүжилтийг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 10

Бүгд: 26

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602900572 төслийн кодтой “Үерийн хамгаалалтын далангийн 2, 3 дугаар ээлжийн байгууламж /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг нь **10,407.8 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **3,122.4 сая** төгрөг” гэсэн арга хэмжээг хасаж, энэ эх үүсвэрээр “Шинэ суурьшлын бүсийн дэд бүтцийн

ажил /Архангай Эрдэнэбулган сум/”, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **25,651.2 сая** төгрөг, санхүүжих дүн **3,122.4 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 8

Бүгд: 26

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808722 төслийн кодтой “Өгийнуур - Мянганы замын хэвтээ тэнхлэг чиглэлийн хатуу хучилттай авто зам, 28.5 км /Хангайн бүс/”, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг нь **43,603.2 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **12,989.4 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2026 онд санхүүжих дүнг **4,853.3 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж /Архангай, Эрдэнэбулган төв сум, 5-р баг, Наранбулаг/ хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **13,263.2 сая** төгрөг, санхүүжих дүн **3,000.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг болон “Тайхар чулуу хүртэлх 3.2 км хатуу хучилттай авто зам /Архангай, Ихтамир сум/”, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **5,853.3 сая** төгрөг, санхүүжих дүн **1,853.3 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 22

Бүгд: 26

15.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **40,000.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **2,400.0 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Ахмадын сувиллын иж бүрэн засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 19-р хороо/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **1,300.0 сая** төгрөг, “Хиймэл оюун мэдээллийн технологийн “Google”-ийн хөтөлбөр хэрэгжүүлэх лаборатори сургуулийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 2-р сургууль/ хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **1,100.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 10

Бүгд: 26

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400293 төслийн кодтой “Тусгай зориулалтын барилга байгууламж, дэд бүтэц /Төвийн бүс/”, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **26,586.5 сая** төгрөг, санхүүжих дүн **7,976.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **600.0 сая** төгрөгөөр, УТ2601400293 төслийн кодтой “Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн ажилчдын орон сууцны барилга, 50 айл /Говь-Алтай, Есөнбулаг сум/”, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг **5,949.2 сая** төгрөг, санхүүжих дүн **2,082.1 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **600.0 сая** төгрөгөөр, УТ2601400232 төслийн кодтой “Тусгай зориулалтын төвийн барилга /Улаанбаатар/”, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **20,132.1 сая** төгрөг, санхүүжих дүн **9,000.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **300.0 сая** төгрөгөөр буюу нийт **1,500.0 сая** төгрөгөөр хөрөнгийн зардлыг бууруулж, Батлан хамгаалах яамны харьяа Үндэсний батлан хамгаалахын Их сургуулийн урсгал зардлыг **1,500.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 8

Бүгд: 26

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402901667 төслийн кодтой “Ховд хотын ундны усны хоёр дахь эх үүсвэр /Ховд, Жаргалант сум/”, хэрэгжих хугацаа 2024-2028 он, төсөвт өртөг **38,071.2 сая** төгрөг, санхүүжих дүн **5,825.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **4,500.0 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Сум, багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Увс, Завхан, Ховд, Говь-Алтай/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **4,500.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 9

Бүгд: 26

65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2102900392 төслийн кодтой “Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтэц /Архангай/”, хэрэгжих хугацаа 2022-2027 он, төсөвт өртөг **26,964.8 сая** төгрөг, санхүүжих дүн **6,118.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **1,608.5 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Нийтийн ариун цэврийн байгууламж бүхий барилгын гадна замын авто зогсоол /Архангай, Цэнхэр сум/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **1,608.5 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 8

Бүгд: 26

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүдийн лабораторийн багаж, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **32,544.4 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **1,200.0 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Кембриджийн хөтөлбөр хэрэгжүүлэх лаборатори сургуулийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 166 дугаар сургууль/”, хэрэгжих хугацаа **1,200.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 8

Бүгд: 26

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601100108 төслийн кодтой “Татварын мэдээллийн системийн дэд бүтэц, серверийн болон татварын албадын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **23,026.9 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **3,320.3 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Газрын тос боловсруулах үйлдвэрийн цахилгаан хангамжийн 110кВ-ын ЦДАШ, 110/35/10кВ-ын Ширээт дэд станц, хэрэгжих хугацаа 2026-2028 он, **16,837.9 сая** төгрөг, санхүүжих дүн **3,320.3 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 8

Бүгд: 26

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гурав.Төсвийн тэнцэлд нөлөөлөхгүй санал.

1.Төсвийн захирагч хооронд шилжүүлэх:

Х.Ганхуяг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын Сэлэнгэ аймгийн Мандал сумын хүүхдийн ордны үйл ажиллагааг орон нутаг руу шилжүүлэх замаар Сэлэнгэ аймгийн суурь зардлыг **421.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 11
Бүгд: 26
57.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр өөрчлөх санал:

Х.Ганхуяг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400557 төслийн кодтой “Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаанд нэн шаардлагатай тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/” гэсэн төсөл, арга хэмжээний “үйл ажиллагаанд нэн шаардлагатай” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 9
Бүгд: 26
65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400570 төслийн кодтой “Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын төрийн өмчийн барилга байгууламжийн хүчитгэл, их засвар /Улсын хэмжээнд/” гэсэн төсөл, арга хэмжээний “хүчитгэл,” гэснийг “сэргээн засварлах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 9
Бүгд: 26
65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602900811 “Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /Архангай, Өвөрхангай/” гэсэн төсөл, арга хэмжээний “Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” гэснийг “Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 10
Бүгд: 26
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын талаарх санал:

Х.Ганхуяг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “16.1.3.4 Цагаатгал, нөхөн олговортой холбоотой хууль тогтоомжийн нэгдмэл байдлыг хангах, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024 он, Суурь түвшин: 25,

Зорилтот түвшин: “40” гэсэн дэд заалт, “16.1.3.5 Их, дээд сургууль болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад хэлмэгдүүлэлт, түүний хор уршгийг таниулах чиглэлээр сургалтад хамрагдсан сурагчдын хувь, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024 он, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10 %” гэсэн дэд заалт тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 9
Бүгд: 26
65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Засгийн газрын 2026 оны төсвийн жилд шинээр үүсгэх өрийн хэмжээнд өөрчлөлт оруулах санал:

Х.Ганхуяг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг буюу “Өрийн удирдлагын тухай хуулийн 28¹.1-д заасан зориулалтаар гаргах аймгийн үнэт цаасны дээд хэмжээг **150,000.0 сая** төгрөг хүртэл” гэсний “аймгийн” гэснийг “аймаг, нийслэлийн” гэж, “**150,000.0 сая** төгрөг” гэснийг “**425,000.0 сая** төгрөг” гэж, холбогдох шийдвэрийн төслийн хамт өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 8
Бүгд: 26
69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв.Зарчмын зөрүүтэй саналын томьёололд нийцүүлэн хуулийн төсөлд өөрчлөлт оруулах санал.

Х.Ганхуяг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан дэмжигдсэн саналуудыг төсвийн тооцоололд бүрэн тусгаж, зарчмын зөрүүтэй дэмжигдсэн саналыг нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг тусгах, үүнтэй уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нарын зарцуулах урсгал болон хөрөнгийн зардал, төвлөрүүлэх орлогын хэмжээ, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ, Нийгмийн даатгалын сангийн болон Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагад нөлөөлөх өөрчлөлт, мөн төслүүдийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлж өөрчлөх, үг хэллэг, нэр томьёог жигдлэх засварыг хийх, мөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төслийн код өгөх, дугаар, эдийн засгийн ангилал, хэрэгжих хугацааг саналын томьёололд нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 9
Бүгд: 26

65.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын 2026 оны төсвийн тооцоололд өөрчлөлт оруулах болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн хэлэлцүүлгийн явцад гарсан саналын томъёололтой холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг үндэслэн холбогдох хуулийн төслийг боловсруулж Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 10

Бүгд: 26

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

БУСАД БАЙНГЫН ХОРООДООС ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:

Нэг.Төрийн байгуулалтын байнгын хорооны санал:

Х.Ганхуяг: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/”, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг **202,137.9 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **23,950.1 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **404.3 сая** төгрөгөөр бууруулж энэ эх үүсвэрээр “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Баян-Адрага сум/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн **404.3 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 21

Бүгд: 26

19.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804408 төслийн кодтой Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7 км /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/”, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг **186,000.6 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **40,000.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **434.1 сая** төгрөгөөр бууруулж энэ эх үүсвэрээр “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Баян-Овоо сум/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн **434.1 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 24
Бүгд: 26

7.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/”, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг **202,137.9 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **23,950.1 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **651.8 сая** төгрөгөөр бууруулж энэ эх үүсвэрээр “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Бэрх тосгон/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн **651.8 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 25
Бүгд: 26

3.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан, Боловсрол, Эрүүл мэнд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбараас бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлыг 0.37 хувиар буюу **29,204.3 сая** төгрөгөөр бууруулж, төслийн 2 дугаар хавсралтын УТ2603800007 төслийн кодтой, “Сонгуулийн ерөнхий хорооны тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/”, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **41,720.4 сая** төгрөг, санхүүжих дүн **12,516.1 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг мөн дүнгээр нэмэгдүүлж, хэрэгжих хугацааг 2026-2026 он гэж өөрчлөх тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 23
Бүгд: 26

11.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан, Төрийн албан хаагчдын өндөр насны тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн буцалтгүй тусламж болох 36 хүртэлх сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний тэтгэмжийн зардалд тусгагдсан санхүүжилтийг **178,089.9 сая** төгрөгөөр нэмэгдүүлж, уг эх үүсвэрийг төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийн урсгал зардлын бараа, үйлчилгээний бусад зардлыг **7.83 хувиар** буюу **178,089.9 сая** төгрөгөөр бууруулах замаар бүрдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

47.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Ч.Анар, Х.Баасанжаргал, Ж.Баярмаа, Д.Бум-Очир, Ж.Галбадрах, Д.Ганмаа, Б.Жаргалан, Ж.Золжаргал, С.Зулпхар, Б.Мөнхсоёл, А.Ундраа, Б.Пунсалмаа, О.Саранчулуун, Б.Хэрлэн, Д.Энхтүвшин нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “34.1.5.3 Түрээсийн орон сууцанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+5%” гэсэн дэд заалт, “34.1.5.4 Түрээсийн орон сууцанд хамрагдсан өрхийн хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+5%” гэсэн дэд заалт, “34.1.1.2 Барилгын зураг төслийн магадлан, барилгын ажлын улсын комисст зарцуулах голч хугацаа буурах хувь, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т-10%” гэсэн дэд заалт, “34.1.1.3 Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ шинээр авч буй барилгад эзлэх ногоон барилгын шалгуур хангасан барилгын эзлэх хувь, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 1, Зорилтот түвшин: 10” гэсэн дэд заалт, “34.1.1.4 Олон нийтийн барилгын орц гарцыг түгээмэл загвараар шийдсэн барилгын хувь, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 11, Зорилтот түвшин: 21” гэсэн дэд заалт, “34.1.5.5 70%-аас дээш эрчим хүчний хэмнэлттэй болгон дулаалсан сууцны нийт сууцанд эзлэх хувь, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: 7, Зорилтот түвшин: 17” гэсэн дэд заалт, “34.3.5.4 Нийт барилга байгууламжийн дундах галын дохиололтой барилгын эзлэх хувийг нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+5%” гэсэн дэд заалт тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 12

Бүгд: 21

42.9 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

48.Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Ч.Анар, Х.Баасанжаргал, Ж.Баярмаа, Д.Бум-Очир, Ж.Галбадрах, Д.Ганмаа, Б.Жаргалан, Ж.Золжаргал, С.Зулпхар, Б.Мөнхсоёл, А.Ундраа, Б.Пунсалмаа, О.Саранчулуун, Б.Хэрлэн, Д.Энхтүвшин нарын гаргасан, Төслийн 1 дүгээр хавсралтын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “35.1.1.2 Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн нийт экспортод эзлэх хувь, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024, Суурь түвшин: Т, Зорилтот түвшин: Т+1%” гэсэн дэд заалт, “35.1.1.3 Үндэсний агуулгатай уран бүтээлийн тоог нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 2500, Зорилтот түвшин: 2550” гэсэн дэд заалт, “35.1.1.4 Авран хамгаалсан соёлын биет өвийн тоог нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 15, Зорилтот түвшин: 30” гэсэн дэд заалт, “35.1.1.5 Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын тоог нэмэгдүүлэх. Хэмжих нэгж: Тоо, Суурь он: 2024, Суурь түвшин: 10924, Зорилтот түвшин: 10974” гэсэн дэд заалт тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 12

Бүгд: 21

42.9 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

49.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601900239 төслийн кодтой “Шинэ Ховд” үйлдвэрлэл технологийн паркийн арьс шир, боловсруулах үйлдвэрийн цэвэрлэх байгууламж /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **9,438.3 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **2,831.5 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2

Татгалзсан: 24

Бүгд: 26

7.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Өргөдлийн байнгын хорооны саналаар санал хурааж дууслаа.

Дөрөв.Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Х.Ганхуяг: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601900237 төслийн кодтой Шинэ Ховд үйлдвэрлэл технологийн паркийн цахилгаан хангамж, гол шугам сүлжээний ажил /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **3,953.6 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **1,779.2 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 23
Бүгд: 26
11.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400215 төслийн кодтой “Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/”, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **8,396.8 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **3,778.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 24
Бүгд: 26
7.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/”, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг **202,137.9 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **23,950.1 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **641.6 сая** төгрөгөөр бууруулж энэ эх үүсвэрээр “Шихихутаг нууц товчоо түүхэн аялал жуулчлалын цогцолборын барилга”-ын нэмэлт төсөв /Хэнтий, Норовлин сум/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн **641.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 25
Бүгд: 26
3.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/”, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг **202,137.9 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **23,950.1 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **238.6 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Их хуралдай цогцолборын барилга”-ын гадна тохижилтын нэмэлт ажил, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн **238.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1

Татгалзсан: 25

Бүгд: 26

3.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг **202,137.9 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **23,950.1 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **685.0 сая** төгрөгөөр бууруулж энэ эх үүсвэрээр “Монголын нууц товчоо цогцолборын барилга”-ын гадна тохижилтын нэмэлт ажил, /Хэнтий, Дэлгэрхаан сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **685.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2

Татгалзсан: 24

Бүгд: 26

7.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606700119 төслийн кодтой “Төрийн цахим үйлчилгээ, хиймэл оюун, их өгөгдлийн суурь дэд бүтцийн тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **19,445.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **700.0 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын төсвийн багцад “Өсвөрийн инженерүүдийн инновацын төвийн барилгын ТЭЗҮ, зураг төсөв”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **700.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 23

Бүгд: 26

11.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 700.0 сая төгрөгөөр бууруулж энэ эх үүсвэрээр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцад “Нийслэлийн түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд унадаг дугуй, скүтэрийн гүүрэн тусгай зам барих ТЭЗҮ, зураг төсөв, хэрэгжих хугацаа 2026-2026

он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 700.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 23
Бүгд: 26
11.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

8.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, *Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Хүнсний болон үрийн буудайн нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, эргэлтийн хөрөнгийн сантай болгоход зориулсан татаасыг 23,000.0 сая төгрөгөөр бууруулах* гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 19
Бүгд: 26
26.9 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Эдийн засгийн байнгын хорооны саналаар санал хурааж дууслаа.

**Тав.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн
байнгын хорооны санал:**

1.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, *Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлд инновац нэвтрүүлэх, тухайн жилд худалдан авсан техникт 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх, бордоог хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох, бэлчээрийн ашиглалт, хамгааллыг сайжруулах, отрын нөөц бэлчээр, усан хангамж, өвс тэжээлийн нөөц, хангамжийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулсан татаасыг 24,300.0 сая төгрөгөөр бууруулах* гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 24
Бүгд: 26
7.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, *Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь “Атрын IV” аянд зориулсан Хүнсний ногооны урамшууллын татаасыг 11,500.0 сая төгрөгөөр бууруулах* гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2

Татгалзсан: 24

Бүгд: 26

7.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, *Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь “Цагаан алт” хөтөлбөрийн ноосны урамшууллын татаасыг 15,600.0 сая төгрөгөөр бууруулах* гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 23

Бүгд: 26

11.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, *Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь арьс ширний урамшууллын татаасыг 6,200.0 сая төгрөгөөр бууруулах* гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2

Татгалзсан: 24

Бүгд: 26

7.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, *Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь “Цагаан алт” хөтөлбөрийн “Бусад арга хэмжээ”-нд тусгагдсан санхүүжилтийг 600.0 сая төгрөгөөр бууруулах* гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 21

Бүгд: 26

19.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, *Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багц дахь “Шинэ хоршоо” хөдөлгөөний зээлийн хүүгийн дэмжлэгийг 608,900.0 сая /133,954.0/ төгрөгөөр бууруулах* гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 22

Бүгд: 26

15.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

7. Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж, Ц.Мөнхбат, Г.Ганбаатар, Р.Эрдэнэбүрэн нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **40,000.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **9,000.0 сая** төгрөгөөр бууруулж, “Онги-Цагаанбургастай” төсөл, төслийн ТЭЗҮ, зураг төсөв, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **44,490.0 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **9,000.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 11
Бүгд: 26
57.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8. Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Р.Сэддорж, Ц.Мөнхбат, Г.Ганбаатар, Р.Эрдэнэбүрэн нарын гаргасан, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багц дахь Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт хөтөлбөрийн зардлыг **856.3 сая** төгрөгөөр бууруулж, Говийг усжуулах судалгааны нэгжийн урсгал зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 23
Бүгд: 26
11.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

9. Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын гаргасан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багц дахь Агаар, орчныг бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн санхүүжилтийг **78,530.8 сая** төгрөгөөр нэмэгдүүлж, энэ эх үүсвэрийг дараах төсөл, арга хэмжээний 2026 онд санхүүжих дүнг бууруулж болон төслөөс хасаж тооцох. Үүнд:

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2600100054 төслийн кодтой, Ерөнхийлөгчийн Тамгын газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **500.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- УТ2600200018 төслийн кодтой, Улсын Их Хурлын Тамгын газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **3,637.5 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2601200838 төслийн кодтой Гадаадын иргэн харьяатын газрын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/”, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **2,365.4 сая** төгрөг, санхүүжих дүн **1,064.5 сая** төгрөг” гэсэн төсөл, арга төсөл, арга хэмжээг хасах;
- УТ2601200355 төслийн кодтой, Цагдаагийн газрын барилга /Булган, Булган сум/”, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 5,353.6 сая төгрөг, санхүүжих дүн **1,606.1 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- УТ2601501976 төслийн кодтой, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн салбар сургуулийн эмнэлгийн барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/”, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **9,237.6 сая** төгрөг, санхүүжих дүн **2,771.3 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- УТ2601501953 төслийн кодтой, Хангайн бүсийн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний цогцолборын гадна тохижилт /Архангай, Эрдэнэбулган сум/”, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **3,126.8 сая** төгрөг, санхүүжих дүн **1,407.1 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- УТ2602800888 төслийн кодтой, Бичигт боомтын төв замаас аялал жуулчлалын бүс нутаг Дарьганга-Байгалийн цогцолборт газар хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Зүүн бүс/”, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **60,156.2 сая** төгрөг, санхүүжих дүн **18,046.9 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- УТ2602800636 төслийн кодтой, Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/”, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **170,899.7 сая** төгрөг, санхүүжих дүн **25,635.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- УТ2603400215 төслийн кодтой, Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/”, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **8,396.8 сая** төгрөг, санхүүжих дүн **3,778.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- УТ2603400522 төслийн кодтой, Спорт заалны барилга /Ховд, Буянт сум/”, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **3,103.4 сая** төгрөг, санхүүжих дүн **1,396.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- УТ2603400239 төслийн кодтой, Спорт заалны барилга /Хөвсгөл, Түнэл сум/”, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **2,156.8 сая** төгрөг, санхүүжих дүн **970.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;

- УТ2603400052 төслийн кодтой, Спорт цогцолборын барилга /Сэлэнгэ, Сайхан сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **6,728.8 сая** төгрөг, санхүүжих дүн **2,018.7 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- УТ2602900939 төслийн кодтой, Инженерийн шугам сүлжээ /Ховд, Дарви сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **2,792.7 сая** төгрөг, санхүүжих дүн **1,256.8 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- УТ2602900037 төслийн кодтой, Үерийн хамгаалалтын барилга, байгууламж, далан суваг /Хөвсгөл, Их-Уул сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **3,652.9 сая** төгрөг, санхүүжих дүн **1,643.9 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- УТ2602900572 төслийн кодтой, Үерийн хамгаалалтын далангийн 2, 3 дугаар ээлжийн байгууламж /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **10,407.8 сая** төгрөг, санхүүжих дүн **3,122.4 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- УТ2602900674 төслийн кодтой, Үерийн хамгаалалтын далангийн байгууламж, 5 км /Завхан, Улиастай сум, Жаргалант, Чигэстэй баг/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **7,829.8 сая** төгрөг, санхүүжих дүн **3,523.4 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- УТ2606700065 төслийн кодтой, Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах станц /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **14,368.5 сая** төгрөг, санхүүжих дүн **4,310.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах;
- УТ2603300016 төслийн кодтой, Авлигатай тэмцэх газрын барилгын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **239.5 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасах;
- УТ2601300963 төслийн кодтой, Цаг уурын харуулын барилга /Баян-Өлгий, Булган, Увс, Баянхонгор, Дундговь, Хөвсгөл, Архангай, Говь-Алтай, Завхан, Ховд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **388.3 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасах;
- УТ2601501638 төслийн кодтой, Дотуур байрын барилга, 75 ор /Сүхбаатар, Халзан сум, 1 дүгээр баг/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,695.5 сая төгрөг, санхүүжих дүн **1,213.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 23
Бүгд: 25

8.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны саналаар санал хурааж дууслаа.

Зургаа.Хууль зүйн байнгын хорооны санал:

Х.Ганхуяг: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2101101137 төслийн кодтой, Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг **546,556.0 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **121,721.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **1,390.0 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны “Тарифт цалингийн жишиг шинэчлэн батлах тухай” 95 дугаар тушаал батлагдсантай холбогдуулан үүссэн зардлын зөрүү **1,111.0 сая** төгрөг, Монгол Улсын дээд шүүхийн байр /Хангарди/-ны гадна фасадыг дулаалах, засварлах ажлыг гүйцэтгэх **279.1 сая** төгрөгөөр санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2

Татгалзсан: 23

Бүгд: 25

8.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800636 төслийн кодтой, Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **170,899.7 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **25,635.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **4,798.0 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Прокурорын газрын цахим хавтаст хэрэг, зөрчлийн системийн сервер, тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг **4,798.0 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **4,798.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 15

Бүгд: 25

40.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804408 төслийн кодтой, Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7 км /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг **216,979.6 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **40,000.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг

12,631.3 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Дүүргийн шүүхийн нэгдсэн барилга /Хан-Уул цогцолбор/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **75,254.5 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **28,663.5 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **12,631.3 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 22
Бүгд: 25
12.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын урсгал зардлыг **300.0 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг **300.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 15
Бүгд: 25
40.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Хууль зүйн байнгын хорооны саналаар санал хурааж дууслаа.

Долоо.Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал:

Х.Ганхуяг: **1.**Улсын Их Хурлын гишүүн Ч.Номингийн гаргасан, Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд өгсөн аудитын дүгнэлтийн 1 дүгээр хавсралтад дурдсан Улсын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй нийт **76,929.5 сая** төгрөгийн төсөвтэй, 18 төсөл, арга хэмжээг хасаж, төсвийн алдагдлыг бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 18
Бүгд: 21
14.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Жудагийн Баярмаагийн гаргасан, Багш, эмч нарын цалинг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор дараах төсөл, арга хэмжээг төслөөс хасаж, хөрөнгийн зардлыг нийт **126,293.4 сая** төгрөгөөр бууруулах. Үүнд:

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/,

хэрэгжих хугацаа 2026-2026 он, гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800805 төслийн кодтой Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 37 км /Өмнөговь, Баяндалай, Гурвантэс сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 106,868.4 сая төгрөг, санхүүжих дүн 20,036.4 сая төгрөг;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800888 төслийн кодтой Бичигт боомтын төв замаас аялал жуулчлалын бүс нутаг Дарьганга-Байгалийн цогцолборт газар хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Зүүн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 60,156.2 сая төгрөг, санхүүжих дүн 18,046.9 сая төгрөг;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800636 төслийн кодтой Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 170,899.7 сая төгрөг, санхүүжих дүн 25,635.0 сая төгрөг;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800770 төслийн кодтой Хатгал-Ханх чиглэлийн 180 км хатуу хучилттай авто замын эхлэл /Хөвсгөл/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 41,350.1 сая төгрөг, санхүүжих дүн 10,100.0 сая төгрөг;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400215 төслийн кодтой Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 8,396.8 сая төгрөг, санхүүжих дүн 3,778.9 сая төгрөг;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400239 төслийн кодтой Спорт заалны барилга /Хөвсгөл, Түнэл сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,156.8 сая төгрөг, санхүүжих дүн 970.6 сая төгрөг;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400052 төслийн кодтой Спорт цогцолборын барилга /Сэлэнгэ, Сайхан сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 6,728.8 сая төгрөг, санхүүжих дүн 2,018.7 сая төгрөг;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606700065 төслийн кодтой Үүрэн холбооны сүлжээ, дахин дамжуулах станц /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 14,368.5 сая төгрөг, санхүүжих дүн 4,310.6 сая төгрөг;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400522 төслийн кодтой Спорт заалны барилга /Ховд, Буянт сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,103.4 сая төгрөг, санхүүжих дүн 1,396.6 сая төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 16

Бүгд: 21

23.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Жудагийн Баярмаагийн гаргасан, Багш, эмч нарын цалинг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор дараах төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацааг хойшлуулах буюу хөрөнгийн зардлыг 53,045.4 сая төгрөгөөр бууруулах. Үүнд:

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200838 төслийн кодтой Гадаадын иргэн харьяатын газрын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,365.4 сая төгрөг, санхүүжих дүн 1,064.5 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200992 төслийн кодтой Дотоод хэргийн их сургуулийн цогцолборын Хилийн албаны сургуулийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 21,343.2 сая төгрөг, санхүүжих дүн 6,403.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200865 төслийн кодтой Хилийн цэргийн 0243 дугаар ангийн авто гарааж, авто засварын барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,017.2 сая төгрөг, санхүүжих дүн 1,357.8 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200851 төслийн кодтой Хилийн цэргийн 0257 дугаар ангийн спорт заалны барилга /Хөвсгөл, Мөрөн сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,078.5 сая төгрөг, санхүүжих дүн 1,385.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200837 төслийн кодтой Хилийн цэргийн ангийн албан хаагчдын орон сууцны барилга /Хөвсгөл, Цагаан-Уул сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 6,534.9 сая төгрөг, санхүүжих дүн 1,960.5 сая төгрөг;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200991 төслийн кодтой Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны, цагдан хорих байрны барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 6,467.8 сая төгрөг, санхүүжих дүн 1,940.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200355 төслийн кодтой Цагдаагийн газрын барилга /Булган, Булган сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он,

төсөвт өртөг 5,353.6 сая төгрөг, санхүүжих дүн 1,606.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;

- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200382 төслийн кодтой Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны, цагдан хорих байрны барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум/”, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,968.3 сая төгрөг, санхүүжих дүн 1,785.7 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200517 төслийн кодтой Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилга /Өвөрхангай, Хархорин сум/”, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 14,609.5 сая төгрөг, санхүүжих дүн 3,652.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400274 төслийн кодтой Зэвсэгт хүчний дүгээр ангийн тусгай сургалт бэлтгэлийн төв /Төвийн бүс/”, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,471.6 сая төгрөг, санхүүжих дүн 1,562.2 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400285 төслийн кодтой Тусгай зориулалтын барилга байгууламж, дэд бүтэц /Баруун бүс/”, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 19,657.7 сая төгрөг, санхүүжих дүн 7,942.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400293 төслийн кодтой Тусгай зориулалтын барилга байгууламж, дэд бүтэц /Төвийн бүс/”, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 26,586.5 сая төгрөг, санхүүжих дүн 7,976.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400232 төслийн кодтой Тусгай зориулалтын төвийн барилга /Улаанбаатар/”, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 20,132.1 сая төгрөг, санхүүжих дүн 9,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх;
- Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601501960 төслийн кодтой Шинжлэх Ухаан Тенологийн Их Сургуулийн оюутны дотуур байрын барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/”, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 18,030.0 сая төгрөг, санхүүжих дүн 5,409.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, 2027 онд шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 14

Бүгд: 21

33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Жудагийн Баярмаагийн гаргасан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын урсгал зардлыг бууруулах хүрээнд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн тооцооллын хавсралт №15-д тусгагдсан зээлийн хүүгийн татаас буюу Шинэ хоршоо-чинээлэг малчин хөтөлбөрийн зээлийн хүүгийн дэмжлэг 108,954.0 сая төгрөгийг хасаж, гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 17
Бүгд: 21
19.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дэмжээгүй саналаар санал хурааж дууслаа.

Байнгын хорооны дарга Х.Ганхуяг 19 цаг 47 минутаас хуралдааныг даргалав.

Долоо.Төсвийн байнгын хорооны санал:

Х.Ганхуяг: 1.Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан, Б.Заяабал, Х.Ганхуяг нарын гаргасан, Засгийн газрын нөөц сангаас **3.5 тэрбум** төгрөгөөр бууруулж сумын төвийн цэвэр, бохир усны нэгдсэн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж. /Ховд, Эрдэнэбүрэн сум/, төсөвт өртөг **3.5 тэрбум**, 2026 онд санхүүжих дүн **3.5 тэрбум**, Засгийн газрын нөөц сангаас **2.1 тэрбум** төгрөгөөр бууруулж “Шинэ Ховд” үйлдвэр технологийн паркийн цахилгаан хангамж, гол шугам сүлжээний ажил /Ховд, Жаргалант сум/, төсөвт өртөг **2.1 тэрбум**, 2026 онд санхүүжих дүн **2.1 тэрбум**, Засгийн газрын нөөц сангаас **2.6 тэрбум** төгрөгөөр бууруулж 35кВт-ын цахилгаан дамжуулах шугам 6300кВт-ын гадастай дэд станцын угсралтын ажил /Ховд, Булган/, төсөвт өртөг **2.6 тэрбум**, 2026 онд санхүүжих дүн **2.6 тэрбум**, Засгийн газрын нөөц сангаас **4.3 тэрбум** төгрөгөөр бууруулж сум, тосгоны эрүүл мэндийн төвийн барилга 10 ор /Ховд, Ховд сум/, төсөвт өртөг **4.3 тэрбум**, санхүүжих дүн **4.3 тэрбум** гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2101101137 төслийн кодтой, Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг **546,556.0 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **121,721.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **3.6 тэрбум** төгрөгөөр бууруулж энэ эх үүсвэрээс сумдын хөдөө аж ахуй, үйлдвэр,

технологийн барилга, хэрэгжих хугацаа 2026- 2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **3.6 тэрбум** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 8
Бүгд: 21
61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800770 төслийн кодтой Хатгал-Ханх чиглэлийн 180 км хатуу хучилттай авто замын эхлэл /Хөвсгөл/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **41,350.1 сая** төгрөг, санхүүжих дүн **10,100.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг Жаргалант, Хатгал, Ханх чиглэлийн 332 км хатуу хучилттай авто замын эхлэл гэж, төсөвт өртгийг 1.1 их наяд төгрөг гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 15
Бүгд: 21
28.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502923292 төслийн кодтой бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах улсын төсвийн хөрөнгө, хэрэгжих хугацаа 2026-2026, төсөвт өртөг **167.0 тэрбум** төгрөг, санхүүжих дүн **47,649.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **5.9 тэрбум** төгрөгөөр бууруулж энэ эх үүсвэрээр Туул голын орчмын үерийн хамгаалалтын байгууламж /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **5.9 тэрбум** гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 10
Бүгд: 21
52.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал, П.Сайнзориг нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800636 төслийн кодтой “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **170,899.7 сая** төгрөг, санхүүжих дүн **25,635.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **4.7 тэрбум** төгрөгөөр бууруулж прокурорын газрын цахим хавтаст хэрэг, зөрчлийн системийн сервер, тоног төхөөрөмж /улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг,

санхүүжих дүн **4.7 тэрбум** гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 13
Бүгд: 21
38.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

6.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын урсгал зардлыг **1.5 тэрбум** төгрөгөөр бууруулж Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын урсгал зардлын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг **1.5 тэрбум** төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 18
Бүгд: 21
14.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800636 төслийн кодтой “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/”, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **170,899.7 сая** төгрөг, санхүүжих дүн **25,635.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **10,000.0 сая** төгрөгөөр бууруулж “Эмээлт, Эко аж үйлдвэрийн парк”-ийн гадна замаас “Эмээлт, Шувуун фабрик” хүртэл 12.5 км замын эхлэл /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2020 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **10.0 тэрбум** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 20
Бүгд: 21
4.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

8.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтыг УТ2503000996 төслийн кодтой аймгийн төвд баригдаж байгаа Дулааны станц төслийн 2 дугаар хэлхээ дэд бүтэц /Баянхонгор, Баянхонгор сум/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг **51.9 тэрбум** төгрөг, санхүүжих дүн **19.8 тэрбум** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5.0 тэрбум төгрөгөөр бууруулж хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүнг 5.0 тэрбум төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 14
Бүгд: 21
33.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

9.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Аж үйлдвэр эрдэс баялгийн яамны хөрөнгийн бусад зарлагыг 4.7 тэрбумаар бууруулж Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны урсгал зардлыг **4.7 тэрбум** төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 8
Бүгд: 21
61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг Б.Мөнхсоёл, Х.Ганхуяг нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтыг УТ210100137 төслийн кодтой гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт улсын хэмжээнд, хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг **546.0 тэрбум** төгрөг, санхүүжих дүн **121.0 тэрбум** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **3 тэрбум 588.0** сая төгрөгөөр бууруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын урсгал зардлыг **2.5 тэрбум** төгрөгөөр нэмэгдүүлэх, Үндэсний аудитын урсгал зардлыг 1.0 тэрбумаар тус тус нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Саналын томьёоллын хавсралт 2.5 дахь арга хэмжээнээс аймгийн төвийн авто замын шинэчлэл /Ховд/, төсөвт өртөг **10.0 тэрбум** төгрөг, санхүүжих дүн **3.3 тэрбум** төгрөгийг **1.2 тэрбум** төгрөгөөр бууруулж “Эрүүл үрс” төвийн барилгын /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/, үлдэгдэл санхүүжилт төсөвт өртөг **1.2 тэрбум** төгрөг, санхүүжих дүн **1.2 тэрбум** төгрөг, хэрэгжих хугацаа 2026-2026 он гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшиний гаргасан, Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийг хэмжээг 6 хувиар нэмэгдүүлэхээр тооцсоныг 30 хувь болгож нэмэгдүүлэхэд шаардлагатай **172,794.0 сая** төгрөгийг нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 18

Бүгд: 21

14.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

13.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшиний гаргасан, Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн урсгал зардлууд болон хангамж, бараа материалын зардал, норматив зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт, зочны зардал, бараа, үйлчилгээний бусад зардлаас **361.0 тэрбум** төгрөгийг хасаж, багш, эмч нарын цалинг **361.0 тэрбум** төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 18

Бүгд: 21

14.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

13.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшиний гаргасан, Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд тусгагдсан төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлаас доорх зардлыг хасах.

“Тохижилт үйлчилгээний зардлаас **12.3 тэрбум** төгрөгийг, сургалт, дадлага, бэлтгэлийн зардлаас **851.0 сая** төгрөгийг тус тус хасах, буурах дүн **13.2 тэрбум** төгрөг, зардал нэмэгдүүлэх төсөл нь УТ2502808717 төслийн кодтой Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл, төсөл, арга хэмжээний санхүүжих дүн **13.2 тэрбум**” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 18

Бүгд: 21

14.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

14.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшиний гаргасан, Монгол Улсын 2026 онд төсвийн төсөвт тусгагдсан төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлаас доорх зардлыг хасах.

“Сургалт, дадлага, бэлтгэлийн зардлаас **3 тэрбум** төгрөг, тавилгын зардлаас **1.8 тэрбум** төгрөг, мэдээлэл сурталчилгааны зардлаас **2.0 тэрбум** төгрөг, багаж, техник хэрэгслийн зардлаас **5.9 тэрбум** төгрөг, тохижилт, үйлчилгээний зардлаас **16.9 тэрбум** төгрөгийг тус тус хасах, буурах дүн **30.0**

тэрбум төгрөг, Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто замд **30.0 тэрбум** төгрөгөөр, санхүүжих дүн, төсөвт өртгийг нэмэгдүүлэх” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 20
Бүгд: 21

4.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

15.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшиний гаргасан, Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд тусгагдсан төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлын сургалт, дадлага, бэлтгэлийн зардлаас “**10.0 тэрбум** төгрөг хасаж, Баянхонгор аймгийн төвөөс Архангай аймгийн Чулуут сум хүртэлх хатуу хучилттай авто замын ажил 1 дүгээр багцын, Санхүүжих дүн: **10.0 тэрбум** төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 19
Бүгд: 21

9.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

16.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшиний гаргасан, Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд тусгагдсан төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлаас сургалт, дадлага, бэлтгэлийн зардлаас **1.4 тэрбум** төгрөг хасаж, зардал нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээнд соёлын төвийн барилгын тайз, технологийн акустик, гадна зам талбайн тохижилтын нэмэлт санхүүжилт, /Завхан, Нөмөргөс сум/, **1.4 тэрбум** төгрөг” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 10
Бүгд: 21

52.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Засгийн газрын нөөц сангаас 3 тэрбум 579 сая 800.0 мянган төгрөг хасаж, сумын төвийн цэвэр, бохир усны нэгдсэн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж /Ховд, Эрдэнэбүрэн сум/, Төсөвт өртөг: 3 тэрбум 579 сая 800 мянган төгрөг, Санхүүжих дүн: 3 сая 579 сая 800 мянган төгрөг;

-Засгийн газрын нөөц сангаас 2 тэрбум 174 сая 400 мянган төгрөгийг бууруулж, Шинэ Ховд үйлдвэр технологийн паркийн цахилгаан хангамж, гол шугам, сүлжээний ажил /Ховд, Жаргалант сум/, Төсөвт өртөг: 2 тэрбум 174 сая 400 мянган төгрөг, Санхүүжих дүн: 2 тэрбум 174 сая 400 мянган төгрөг;

-Засгийн газрын нөөц сангаас 2 тэрбум 641 сая 500 мянган төгрөгөөр бууруулж, 35 кВт-ын цахилгаан дамжуулах шугам 35/10/6300 кВт-ын гадастай дэд станцын угсралтын ажил /Ховд, Булган сум/, Төсөвт өртөг: 2 тэрбум 641 сая 500 мянган төгрөг, Санхүүжих дүн: 2 тэрбум 641 сая 500 мянган төгрөг;

-Засгийн газрын нөөц сангаас 4 тэрбум 309 сая 400 мянган төгрөгөөр бууруулж, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Ховд, Ховд сум/, Төсөвт өртөг: 4 тэрбум 309 сая 400 мянган төгрөг, Санхүүжих дүн: 4 тэрбум 309 сая 400 мянган төгрөг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 8

Бүгд: 21

61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлэг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 20 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 5 цаг 02 минут үргэлжилж, 29 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 79.3 хувийн ирцтэйгээр 20 цаг 07 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.ГАНХУЯГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
12 цаг 33 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Ганхуяг: Та бүхэнд ирцийг танилцуулъя.

Жуковын Алдаржавхлан, Жигжидийн Батжаргал, Хөххүүгийн Болормаа гишүүн, Пүрэвжавын Ганзориг гишүүн, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн, Пүрэвжавын Сайнзориг гишүүн, Норовын Алтанхуяг гишүүн, Жамбын Батсуурь, гишүүн, Жамбалын Ганбаатар гишүүн, Хассуурийн Ганхуяг гишүүн, Далайн Батбаяр гишүүн, Батжаргалын Заяабал гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн нар хүрэлцэн ирсэн байна. Т.Аубакир сайд хүрэлцэн ирсэн байна. Р.Батболд гишүүн хүрэлцэн ирсэн байна.

Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн ирээгүй байна.
Чинбатын Номин гишүүн ирээгүй байна.
Банзрагчийн Түвшин гишүүн ирээгүй байна.
Загджавын Мэндсайхан гишүүн ирээгүй байна.
Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн гишүүн ирээгүй байна.
Даваагийн Цогтбаатар гишүүн ирээгүй байна.

Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн орж ирээрэй.

Ганзоригийн Тэмүүлэн гишүүн ирээгүй байна.
Баттогтохын Чойжилсүрэн гишүүнийг дуудаарай. Ирсэн байсан шүү.

Ирц бүрдсэн тул Төсвийн байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хуралдаанд оролцож байгаа Байнгын хорооны гишүүдийн ирцийг танилцуулсан.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя.

Нэг. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүд.

Засгийн газар 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

Хоёр. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл.

Засгийн газрын 2025 оны 9 сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн. Гурав дахь хэлэлцүүлэг.

Эхний асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор өөр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

**Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй
хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд
/Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж байгаа асуудалтай. Холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Ням-Осорын Учрал Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Буриадын Дашпүрэв Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сэрээнэндоржийн Төгсжаргал Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Төмөрийн Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга ирээгүй юм байна. Бусад нь байхгүй юм байна. Тийм ээ. Өөр хүн байгаа юм уу?

Төсвийн байнгын хорооны 2025 оны 22 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгээс Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар гаргасан танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа уншиж танилцуулна.

Д.Үүрийнтуяа: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 сарын 01-ний өдөр Монгол Улсын Их Хуралд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2025 оны 10 дугаар сарын 17, 24-ний өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хорооны 2025 оны 22 дугаар тогтоолоор Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Байнгын хороо болон нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Ц.Баатархүү, Ж.Баясгалан, Б.Бейсен, Г.Лувсанжамц, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа, Д.Энхтүвшин нар ажиллаж байна.

Ажлын хэсэг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдтэй холбогдох тооцоолол, мэдээлэл болон хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөлд ирүүлсэн саналтай танилцсан.

Ажлын хэсэг 3 удаа хуралдаж, хуулийн төсөл болон Улсын Их Хурлын тогтоолын төслийг заалт тус бүрээр Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах асуудлыг Байнгын хорооны хуралд танилцуулж байна. Үүнд:

1.багш, эмч нарын эмнэлгийн байгууллагын ажилчдын цалин болон ахмад настны тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлж байгаатай холбогдуулан татварын зардлыг бууруулах зорилгоор нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжих хугацааг хойшлуулж, хуулийг 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх.

2.“Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хувьд Тавантолгойн бүлэг ордын ашиглагдаагүй байгаа хэсгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, орд ашиглалтыг сайжруулахдаа хөрөнгө оруулагчийг нээлттэй сонгон шалгаруулах, бүтээгдэхүүний арилжааг хуулийн хүрээнд нээлттэй, ил тод, үр ашигтай зохион байгуулах зарчмын асуудлыг төсөлд тусгах саналыг бэлтгэлээ.

Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдэд найруулгын болон хууль зүйн техникийн саналыг бэлтгэсэн болно.

Ажлын хэсэг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн талаарх

зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг томьёолж бэлтгэн Та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Ганхуяг: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу Эдийн засгийн байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцээд санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд ирүүлснийг Та бүхэнд тараасан байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэхээр заасны дагуу Монгол Улсын 2026 онд Төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг зүйл тус бүрээр хэлэлцэж эхэлье.

Нэг.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Ажлын хэсгийн саналыг Та бүхэнд танилцуулъя.

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 17¹ дүгээр зүйл нэмэх:

“17¹ дүгээр зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

17¹.1.Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1.а дахь дэд заалтыг 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал дагаж мөрдөнө.

17¹.2.Энэ хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1.б дэх дэд заалтыг 2027 оны төсвийн жилээс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, М.Бадамсүрэн, Ц.Баатархүү, Ж.Баясгалан, Б.Бейсен, Г.Лувсанжамц, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа, Д.Энхтүвшин. Цаашид “Ажлын хэсэг” гэх.

Санал хураалтдаа бэлдье. Тийм ээ. Ж.Алдаржавхлан гишүүн ороогүй байна. Н.Алтанхуяг гишүүн ороогүй байна. Т.Аубакир сайд ороогүй байна. Далайн Батбаяр орсон уу? Сайд ороогүй байна шүү. Б.Чойжилсан сайд ороогүй байна. Тийм. Д.Пүрэвдаваа гишүүн ороогүй байна. Б.Заяабал гишүүн байна уу? Б.Заяабал гишүүн ороогүй байна. Д.Энхтүвшин гишүүн ороогүй байна. Байна уу?

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Ажлын хэсгийн саналыг хураая. Санал хураалт. /алх цохив/

68.2 хувь дэмжлээ.

1 дүгээр зүйлтэй холбогдуулан Г.Лувсанжамц гишүүн санал гаргасан байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 15.2.1.б. дэх дэд заалтыг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц.

Ажлын хэсгийн санал дэмжигдсэн тул энэ саналыг хураахгүй юм байна шүү.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 15.2.1.а дахь дэд заалтын “2026 оны татварын жилд” гэснийг, 15.2.1.б дэх дэд заалтын “2027 оны татварын жилээс эхлэн” гэснийг “албан татвар төлөгчийн албан татвар суутган төлөгчтэй хийсэн” гэж, “1 дүгээр зүйл” гэснийг “2 дугаар зүйл” гэж, “2 дугаар зүйл” гэснийг “3 дугаар зүйл” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

77.3 хувь дэмжсэн байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна.

3.Төслийн 2 дугаар зүйлийн “01 дүгээр” гэснийг “10 дугаар” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

77.3 хувь дэмжсэн байна.

4.Саналын томъёололын 1 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэрийн “ӨӨРЧЛӨЛТ” гэсний өмнө “НЭМЭЛТ, ” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

77.3 хувь дэмжсэн байна.

Хоёр.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 6 зүйлтэй.

Дээрх хуулийн төслийг Эдийн засгийн байнгын хороо хэлэлцээд санал, дүгнэлтийг ирүүлснийг Та бүхэнд тараасан байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Бичгээр хоёр гишүүн санал ирүүлсэн байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 18.4 дэх хэсгийн “хийж болно.” гэснийг “хийнэ.” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин.

Д.Үүрийнтуяа гишүүн тайлбар байгаа юу? Д.Үүрийнтуяа гишүүний микрофоныг.

Д.Үүрийнтуяа: Ажлын хэсгийн дэмжсэн саналууд дээр зарчмын зөрүүтэй саналууд дээр нэгтгэлээ оруулаад ажлын хэсэг саналаа нэгтгээд оруулсан байгаа.

Ажлын хэсэгт гаргасан Д.Энхтүвшин гишүүний санал ажлын хэсгээр дэмжигдээгүй санал. Ажлын хэсгийн гишүүнд байгаа. Өөрөө.

Х.Ганхуяг: Ойлголоо. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна.

Бичгээр нэг санал ирсэн байна. Ажлын хэсгийн дэмжигдээгүй санал.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 6 дахь заалтыг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 8 дахь заалтын 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.1.7 дахь заалт нэмэх:

“25.1.7.нийгмийн нөлөөллийн шинжилгээний санал, дүгнэлт;”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат. Ажлын хэсэгт дэмжигдээгүй санал байна. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй.

М.Энхцэцэг гишүүний санал Эдийн засгийн байнгын хороон дээр бас давхар хураагдсан юм байна. Тэнд бас дэмжигдээгүй юм байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Бичгээр ирсэн ажлын хэсгийн найруулгын саналыг Та бүхэнд уншиж танилцуулъя.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн “8.1.3 дахь заалтын “төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, Засгийн газраар хэлэлцүүлэх зөвшөөрлийг авах” гэснийг

“төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтийг авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлэх” гэж, мөн зүйлийн” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Бичгээр Д.Энхтүвшин гишүүнээс санал ирсэн байна. Ажлын хэсэг нь дэмжигдээгүй санал.

5.Төслийн 5 дугаар зүйлийн “заалт, 17 дугаар зүйлийн 17.1.2.6 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.4.2 дахь” гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуултаа асуух гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Гурав.Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Бичгээр ирсэн саналыг Та бүхэнд танилцуулъя. Ажлын хэсгийн дэмжээгүй санал.

1.Төслийн 1 дэх заалтын “12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3-т” гэснийг “12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3, 12.1.5-д” гэж, мөн заалтын “мөн зүйлийн 12.1.4-т” гэснийг “мөн зүйлийн 12.1.4, 12.1.5-д” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг.

Саналаа тайлбарлана. П.Сайнзориг гишүүний микрофон өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Би Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа.

Дотоод бондыг зөвхөн төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор гаргана гэсэн байсан.

Тэгэхээр энэ дээр уг нь 12.1.5-ыг нэмж байгаа агуулга нь юу вэ гэхээр Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.5 бол Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх.

Гадаад бонд дээр 1 тэрбум долларыг босгоно гэсэн байна лээ. Энэ дээр мөн өрийн удирдлагыг л зохицуулах зорилго гаргана гэсэн.

Тэгэхээр уг нь ирэх жил өрийн удирдлагын асуудал дээр асуудал гайгүй гэж хэлж байсан. Гэхдээ энэ танилцуулга, энэ үнэт цаас гаргах юман дээр бас жоохон ойлгомжгүй нөхцөл байдал байна.

Үнэхээр асуудал гайгүй байгаа юм бол энэ Өрийн удирдлагын тухай хуулийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд бас үнэт цаас гаргаж болдоггүй юм уу? Зөвхөн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор дотоод бонд босгох гээд байгаа нь ямар учиртай юм бэ? Энэ дээр ч гэсэн аль аль агуулгаар нь Засгийн газарт эрхийг нь өгчихвөл яадаг юм бэ л гэдэг зүйл байгаа.

Тэгээд өнөөдөр төсвийн урсгал зардал дээрээ бид хэд боомилуулаад цаашдаа янз бүрийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бололцоогүй болоод байгаа учраас аль болохоор өөр өөрийгөө санхүүжүүлэх, эргэн төлөх бололцоотой байдлаар үнэт цаас гаргах эрхийг нь Засгийн газартаа арай уужуу өгмөөр байгаа байхгүй юу. Үүнийг өгч байгаа нь тэг гэсэн үг биш шүү дээ. Ер нь боломжийг хадгалаад аль үндэстэй байдлаар шийдээч ээ л гэдэг бодол байна.

Тэгэхээр үүнийг Байнгын хорооны гишүүд дэмжээд өгөөч. Засгийн газарт зөвхөн зориулалт нь ийм хязгаарлагдмал байж болох юм уу, үгүй юу гэдэг дээр та хэд маань бодоод хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх байдлаар дотоод, гадаад бонд, үнэт цаас гаргах эрхийг нь өгчихье гэдэг л санал байгаа шүү. Тэгээд дэмжээд өгөөч ээ л гэж хүсэж байна.

Х.Ганхуяг: Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй.

Дөрөв.Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороо хэлэлцсэн. Санал, дүгнэлтийг Та бүхэнд тараасан байгаа.

Байна гэсэн. Тийм ээ? П.Сайнзориг гишүүний микрофон өгье.

П.Сайнзориг: Энэ тогтоол бол зүгээр гоё зорилготой. Зорилгыг нь эрх зүйгээр тайлбарлаадахъя.

Тэгэхдээ яг бичилт томьёоллоо Та бүгд хараарай.

Улсын Их Хуралд эргэж танилцуулахгүйгээр Тавантолгой эдийн засгийн эргэлтэд ороогүй бусад ордуудыг шууд эдийн засгийн эргэлтэд оруулах. Тэр нь үүнийг “урт хугацааны цогц гэрээгээр хийж шийднэ” гэдэг үг, өгүүлбэртэй. Энэ чинь юу вэ гэхээр нөгөө нүүрсийг чинь биржээр зарах биш, нөгөө нүүрсийг чинь ил тодоор үнэ хаялцуулж зарах биш, үүнийг чинь урт хугацааны олборлолт, тээвэрлэлт, экспорт гэсэн зарчмаар урт хугацааны гэрээ хийхээр орж ирсэн байгаа шүү.

Тэгэхээр энэ асуудал дээр гишүүд маань анхааралтай хандаач ээ. Энэ дараагийн яг оффтейк гэрээ байгуулах гээд байгаа. Үүнийг олон гишүүд уг нь ярьж байсан. Тэгээд миний бие энэ дээр хоёр зарчмын санал, нэг нь найруулгын санал гаргаж байгаа. Тэгээд санал дээрээ тайлбарлая.

Би зүгээр энэ зүйлүүдийг өнгөцхөн хараад явуулах юм бол дараагийн дахиад оффтейк гэрээ зурах эрхийг бид төсөв дагаж өгөх гээд байна шүү. Энэ дээр гишүүд маань анхааралтай хандаач ээ л гэдэг зүйлийг хэлмээр байна.

Х.Ганхуяг: Ажлын хэсгийн даргын микрофоныг өгье. Д.Үүрийнтуяа гишүүн.

Д.Үүрийнтуяа: П.Сайнзориг гишүүний зарчмын зөрүүтэй саналууд ажлын хэсэг дээр яригдсан.

Тогтоолын төслийн 1.2 дахь хэсэгт таны ярьж байгаа зүйл дээр гишүүдийн санаа зовж байгаа, магадгүй оффтейк гэрээ хийгдэх гэж байгаа юм биш биз дээ гэсэн хардлага сэрдлэг төрүүлсэн үг, үсэгтэй байна гэдэг зүйлүүдийг нэлээдгүй ярилцсан.

Энэ дээр холбогдох яамд, Эрдэнэс Тавантолгойгоос бүх нэмэлт мэдээлэл, тодруулгуудыг авч ажлын хэсгийн саналаар 1.2 дахь хэсгийг хасаж, 1.3 дахь хэсэг дээр найруулгын өөрчлөлт хийж оруулсан байгаа.

Ажлын хэсгийн зарчмын зөрүүтэй саналаар энэ орж ирнэ. Энэ бүх гэрээ хэлцэл, сонгон шалгаруулалт, хөрөнгө оруулагчийг шалгаруулах, гэрээ хэлцэл хийх энэ бүх процесс нь холбогдох хууль тогтоомжийнхоо хүрээнд ил тод, нээлттэй, үр ашигтай байх зарчмыг баримталж үүний зохион байгуулалтыг хий гэдэг үүрэг, чиглэлийг найруулгын хувьд оруулж өөрчилсөн байгаа гэдгээ хэлье.

Х.Ганхуяг: П.Сайнзоригийн микрофон өгье.

П.Сайнзориг: Тэгэхээр Д.Үүрийнтуяа дарга аа, ингэж ойлголоо. Зөв үү? Тогтоолын төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын хэрэгжүүлэхдээ урт хугацааны гэрээний үндсэн дээр иж бүрэн цогцоор ашиглах талаар олборлолт, тээвэрлэлт, экспортыг гүйцэтгэх, хамтрагч, хөрөнгө оруулагчид санал болгож хэлцэл хийх замаар эргэлтэд оруулах гэснийг хасаж байгаа гэж ойлгож байгаа. Зөв үү? Үүнийг хэлээч.

Тэгэхээр ийм юм байгаа. Үүнийг тайлбараараа хэлэлцээр хийх гэж байгаа юм гээд байгаа боловч “хэлэлцээр”, “хэлцэл” хоёр чинь өөр юм.

Тэгэхээр хэлэлцээр бол мэдээж “процесс” буюу “үе шат” явж байгаа бол энэ дээр чинь бүр “хэлцэл хий” буюу “хэлцэл” гэдэг чинь өөрөө “гэрээ” байхгүй юу.

Тэгэхээр энэ эрхийг хасаж байгаа бол би дараагийн гаргах саналаа татаж болно. Үүнийг та тодруулаад микрофонд протоколын хувьд үлдээгээд өгөөч ээ.

Тэгээд аль болохоор үүнийг ил тодоор явуулах нь зүйтэй гэж үзэж байгаа.

Тэгэхээр энэ дээр зарчимч тийм. Уг нь Улсын Их Хурлын тогтоол дээр дурдаад байх асуудал биш байхгүй юу. Харин Улсын Их Хуралд эргэж танилцуулаад ямар хэмжээний хэлцээрийн төслийг оруулж ирэв гэдэг дээрээ мандатаа аваад гарах ёстой юмыг... /минут дуусав/

Х.Ганхуяг: Д.Үүрийнтуяа гишүүний микрофон өгье.

Д.Үүрийнтуяа: Би сая танд хариулсан.

Засгийн газраас өргөн барьсан Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1.2 буюу энэ тогтоолын 1.1 дэх заалтыг хэрэгжүүлэхдээ “урт хугацааны гэрээний үндсэн дээр иж бүрэн, цогцоор нь ашиглах талаар олборлолт, тээвэрлэлт, экспортыг гүйцэтгэх, хамтрагч, хөрөнгө оруулагчдад санал болгож, хэлцэл хийх замаар эргэлтэд оруулах” гэдэг заалтыг хассан.

1.3-д байсан. Одоо энэ тогтоолын 1.1, 1.2 дахь хэсэгт заасан “хэлцлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод, нээлттэй, үр ашигтай хийх” гэдгийг дараах байдлаар өөрчлөн найруулсан.

Энэ тогтоолын 1 дэх дэд заалтыг хэрэгжүүлэхдээ “хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах, бүтээгдэхүүн арилжаалах зэрэг бүхий л үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод, нээлттэй, үр ашигтай зохион байгуулах” гэж томъёолсон байгаа.

Х.Ганхуяг: Ажлын хэсгийн томъёоллыг Та бүхэнд танилцуулъя.

1.Төслийн 1 дэх заалтын “Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах” гэснийг “Монгол Улсын Үндсэн хуульд заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх, түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдох зарчмын” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дахь дэд заалтыг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдлээ.

П.Сайнзориг гишүүний санал давхацсан байна. Ажлын хэсэг санал дэмжигдсэн тул П.Сайнзориг гишүүний саналыг уншаад танилцуулъя.

1.Төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “хэрэгжүүлэхдээ урт хугацааны гэрээний үндсэн дээр иж бүрэн цогцоор нь ашиглах талаар олборлолт, тээвэрлэлт, экспортыг гүйцэтгэх хамтрагч, хөрөнгө оруулагчдад санал болгож, хэлцэл хийх замаар эргэлтэнд оруулах,” гэснийг “хэрэгжүүлэх үүднээс холбогдох хэлэлцээрийг ил тод, Монгол Улсын эрх ашигт нийцсэн байдлаар хийж Улсын Их Хуралд танилцуулан хэлэлцүүлэх,” гэж өөрчлөх.

3.Төслийн 3 дахь дэд заалтыг доор дурдснаар өөрчлөн найруулах:

3/Энэ тогтоолын 1 дэх дэд заалтыг хэрэгжүүлэхдээ хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах, бүтээгдэхүүн арилжаалах зэрэг бүхий л үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод нээлттэй, үр ашигтай зохион байгуулах;

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

76.0 хувиар санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн санал дэмжигдсэн тул гишүүдээс бичгээр ирсэн саналуудыг Та бүхэнд танилцуулна.

Төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтыг хасах.

Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 5 дахь дэд заалт нэмэх:

“5/Тавантолгойн бүлэг ордтой холбоотойгоор байгуулсан, хэрэгжүүлсэн төрийн нууцад авсан гэрээ, хэлцэл, тэдгээрийг байгуулахыг зөвшөөрсөн, дэмжсэн төрийн нууцад авсан холбогдох бүх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу төрийн нууцаас гаргах арга хэмжээг 2026 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор авч хэрэгжүүлж, Монгол Улсын Их Хуралд тайлагнах.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг.

П.Сайнзориг гишүүний микрофон өгье.

П.Сайнзориг: Нийгмийг талцуулж байгаа, бүгд л нүүрсний хулгайч ч юм шиг ийм зүйл рүү оруулж байгаа нэг юм байна.

Энэ үе үеийн үед байгуулсан оффтейк гэрээ. Оффтейк гэрээг байгуулсан энэ оффтейк гэрээнүүдийг ил тод болголоо гээд байгаа боловч бас болоогүй байна. Гэрээг болгох нэг асуудал. Энэ гэрээнүүдийг байгуулах зөвшөөрлийг хэн олгоод байдаг юм бэ? Хэний шийдвэрээр энэ гэрээг байгууллаа гэдэг чиглэлийг өгөөд байдаг юм бэ гэдэг зүйлийг мэдэх ёстой. Ингэж байж Тавантолгойн бүлэг ордыг тойрсон хэрүүл тэмцэл дээр хэн нь ямар эрх ашигтай оролцож байсан юм бэ гэдэг зүйл нь гарна.

Тийм учраас 5 дугаар дэд заалт нэмэх гэж байгаа нь Тавантолгойн бүлэг ордтой холбоотой байгуулсан, хэрэгжүүлсэн, төрийн нууцад авсан гэрээ хэлцэл, тэдгээрийг байгуулахыг зөвшөөрсөн, дэмжсэн, төрийн нууцад авсан, холбогдох бүх шийдвэрийг ил тод болгоё гэж байгаа шүү.

Тэгэхээр гишүүд маань үнэхээр нүүрсний хулгайтай тэмцье, Тавантолгойг тойрсон бүх асуудлыг цэгцэлье гэж байгаа бол үүнийг дэмжиж өгөөсэй гэж хүсэж байна.

Тэгээд эргээд 3 сарын 01-ний дотор энэ арга хэмжээг аваад Улсын Их Хуралд тайлагнах үүргийг Засгийн газарт өгч байгаа. Түүнээс биш хэдэн гэрээнүүдийг ил тод болголоо гээд нийгмийн талцуулах биш, энэ гэрээг ямар шийдвэрээр байгуул гэдэг чиглэлийг өгөөд байсан юм бэ гэдэг зүйлийг ил тод болгож байж хамтад нь ярих ёстой.

Тэгэхээр гишүүд маань энэ дээр Та бүгд одоо яг л хулгайтай тэмцье, нүүрсний хулгайтай тэмцье, үнэхээр ил тод байдлыг хангуулъя гэж байгаа бол үүнийг дэмжиж өгөхийг хүсэж байна. Олон нийт ч харж байгаа.

Баахан гэрээнүүдийг ил тод болгоно л гээд байдаг мөртөө хэний зөвшөөрлөөр, хэн чиглэл өгөөд, аль институцийн ямар шийдвэрээр байгуулаад байсан гэдэг нь одоо хүртэл байхгүй. Тэгээд түрүүчээсээ баахан мухар төмөр замтай. Үүнийгээ зөрчсөн. Холбохын тулд дахиад бөөн зардал гарсан. Эргээд янз янзын нүүрсний ангиллаасаа шалтгаалаад олон асуудлууд гарч байгаа.

Тэгэхээр энэ асуудлуудыг яг ил тод болгох үнэхээр улс төрийн хүсэл зориг, парламентын хүсэл зориг байгаа бол үүнийг дэмжиж өгөөч ээ. 2026 оны 3 дугаар сарын 01-ний дотор энэ арга хэмжээг аваад буцаагаад Улсын Их Хуралд тайлагнах үүргийг Засгийн газарт өгч байгаа шүү. Одоо энэ дээр тэгээд олон нийтэд хэн нь нүүрсний хулгайтай тэмцэж байгаа, тэмцэхгүй байгаагаа харуулах нь зөв байх.

Х.Ганхуяг: Ажлын хэсгийн ахлагчийн микрофоныг өгье. Асуугаагүй юм уу?

Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй.

Ажлын хэсгийн санал дэмжигдсэн тул Д.Энхтүвшин гишүүний бичгээр ирсэн саналыг уншиж танилцуулъя.

4.Төслийг хууль санаачилагчид нь буцаах.

Хураах юм уу? Зүгээр танилцуулах юм уу?

Б.Пүрэвдорж гишүүний саналыг танилцуулъя.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “10 хувиар” гэснийг “5 хувиар” гэж өөрчлөх.

С.Эрдэнэбат гишүүний саналыг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай 2025 оны 48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт буюу Монгол Улсын 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд туссан төсвийн урсгал зардлыг бууруулж, дотоодын нийт бүтээгдэхүүний 24 хувиас хэтрүүлэхгүй байна гэснийг хүчингүйд тооцох.

С.Эрдэнэбат гишүүний саналыг танилцуулъя.

Монгол Улсын 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд туссан “дотоодын нийт бүтээгдэхүүний 24-өөс хэтрэхгүй” гэснийг “дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрүүлэхгүй” гэж өөрчлөх.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3.2-т хуулийн төсөлд хөндөгдөөгүй зүйл, хэсэг, заалт, дэд заалтад өөрчлөлт оруулахыг хориглоно гэсний үндсэн дээр санал хураалгах боломжгүй саналууд байна.

Д.Үүрийнтуяа гишүүний микрофон өгье.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа.

Би асуултад хариулах гээгүй. Гэхдээ П.Сайнзориг гишүүн ээ, би ажлын хэсгийн ахлагчийн хувьд энэ үл ойлголцлын асуудал үүсэхээр тайлбарууд яваад байгаа учраас би энэ дээр тайлбар хэлэхгүй бол болохгүй нь.

Төсөв дагаж орж ирж байгаа хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд Төсвийн хуулийн заалтын дагуу тухайн төсвийн жил болон төсвийн хүрээнд төсвийн төсөөлөлд нөлөөтэй байх ёстой. Эдийн засгийн агуулгаараа ямар нэгэн байдлаар холбогдож байж энэ заалтууд орох ёстой юм.

Тухайн жилийн төсөвт эдийн засгийн агуулгаараа холбогдоогүй зүйл, заалтыг бид нэмж оруулах боломжгүй юм. Боломжгүй юм.

Улсын Их Хурлын тухай хуулиар. Та хуульч хүн. Төсвийн тухай хуулиа үзээрэй. Улсын Их Хурлын тухай хуулиар хуулийнхаа хэрэгжилтийг хянах, шалгах, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх бүрэн эрх нь Улсын Их Хуралд байна. Заавал төсөв дагасан хуулийг дагаж бүх асуудлыг оруулах биш, энэ асуудлаа тусдаа шийддэг горимоороо шийдэх хэрэгтэй. Таны саналыг дэмжиж байна. Гэхдээ төсөв дагаж орж ирсэн тогтоол дээр орох нь өөрөө төсвийн хуультай зөрчилдөж байгаа юм. Энэ асуудлыг ажлын хэсэг дээр яриагүй биш ярьсан.

Тийм учраас Улсын Их Хурлын гишүүдийг бодвол та энэ саналын татгалзсан, зөвшөөрснөөр нь зургийг нь аваад байх шиг байна л даа. Гишүүд рүү ийм дайралт хийж болохгүй л дээ.

Яагаад гэвэл бид хуулиар үлдээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллаж байгаа хүмүүс. Төсвийн хуулийг батлахдаа бид төсвийн тухай хуулиа барьж байж, энэ үндсэн заалтуудаа барьж байж ажиллах ёстой юм.

Түүнээс таны хууль санаачлах эрхэд халдаж байгаа гэдэг юм уу, эсвэл хулгайтай тэмцэхгүй гэсэн дээ энэ асуудлыг хасаж байгаа зүйл биш шүү гэдгийг Та зөвөөр ойлгоорой. Хуульч хүний хувьд.

Х.Ганхуяг: Хууль, тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хороодоос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нэгдсэн хуралдаанд танилцуулна. /алх цохив/

Хууль, тогтоолын төслүүдийг анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

**Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль,
Үндэсний баялгийн сангийн тухай 2026 оны төсвийн тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд
/Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
гурав дахь хэлэлцүүлэг/**

Хоёр. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Түрүүний ажлын хэсэг хэвээрээ.

Үүн дээр нэмээд Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав, Аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга Б.Баттуяа, Аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хэвээрээ гэсэн үг.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 онд төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 онд төсвийн тухай хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан сайдыг дуудаарай. Дуудаж байна уу? нөгөө. Саналын томъёоллууд хэвлэгдэж байгаа. Танилцуулга явсны дараагаар тараагаад. Болохгүй бол 10 минут завсарлаж байгаад тараасны дараа эхлүүлж болно. Тийм. Хүлээж байна. Одоо бид өдөр шөнөгүй л суулаа.

Б.Жавхлан сайд байгаа юм уу, байхгүй юм уу? Тэгвэл 30 минут завсарлчихъя. 30 минут буюу 13 цаг 45 минутаад хурлаа үргэлжлүүлъя.

Нөгөө хэвлээд байна л даа. Өнөөдөр цөмөөрөө төсвөө ямар ч байсан дуусгачихмаар байна. Тэгвэл хурлыг 15 цаг 30 минутаас үргэлжлүүлж хуралдуулъя. /13:13/

Гишүүд тэнхимдээ орж ирээрэй. Танилцуулгаасаа эхэлнэ. Ажлын хэсэг ажлын хэсгийг оруулж ирээрэй.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Сангийн сайд Болдын Жавхлан. Микрофоныг өгье. Сайдын микрофоныг өгөөрэй.

Б.Жавхлан: Эрхэм Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулж, 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Ирэх 2026 оны төсвийн төслийг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөтэй уялдуулан боловсрууллаа.

Төсвийн төсөлд туссан тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах онцлох арга хэмжээг дурдвал –

► **Нэгдүгээрт**, төсвийн урсгал зардал нь өмнөх оноос 585.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байгаа. Үүнд:

■ хууль тогтоомжид заасны дагуу –

- тэтгэврийн хэмжээг жил бүр инфляцын түвшинтэй уялдуулан нэмэхэд 378.0 тэрбум төгрөг,
- хүүхэд, ахмад нас, насны тооны өсөлтөөс шалтгаалсан халамжийн зардал 45.3 тэрбум төгрөг,
- сурагчийн тооны өсөлттэй холбоотой боловсролын салбарын зардал 81.2 тэрбум төгрөг,
- хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор улсын төсвөөс хариуцах Эрүүл мэндийн даатгалын шимтгэл болон тусламж, үйлчилгээний зардал 79.0 тэрбум төгрөг зэрэг зайлшгүй нэмэгдэх зардлууд нөлөөлсөн байна.

► **Хоёрдугаарт**, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хуульд заасны дагуу 2025 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн иргэдээс санал авч, сум, дүүрэг, аймаг, нийслэл, салбар яамны түвшинд үе шаттайгаар төлөвлөсөн.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр нийт 14.4 их наяд төгрөгийн санхүүжих дүн бүхий 1712 төслийн санал хүлээн авснаас холбогдох шалгуур үзүүлэлт, зарчим, бодлогыг харгалзан эрэмбэлж 579 төсөл, арга хэмжээнд 3 их наяд 267.3 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгасан болно.

- ▶ **Гуравдугаарт,** Засгийн газрын өрийн хувьд Улсын Их Хурлаас 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр баталсан Засгийн газрын Өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийн зорилт, арга хэмжээг мөрдөн ажиллах бөгөөд 2026 онд Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрүүдийг тэргүүн ээлжид хэрэгжүүлэх 1 тэрбум ам.доллар хүртэл Засгийн газрын өрийн баталгаа гаргах, аймаг нийслэлийн үнэт цаасыг зохистой хэмжээнд арилжаалах дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжиж суурь хүүг тогтоох зорилгоор 562.0 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаас гаргах, дахин санхүүжүүлэх зорилгоор 1 тэрбум ам.доллар хүртэл гадаад үнэт цаас арилжаалахаар төсвийн төсөлд тусгалаа.
- ▶ **Дөрөвдүгээрт,** Үндэсний баялгийн сангийн хувьд “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын 4.6-д заасан зорилтыг хангах хүрээнд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр баталж, хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш нэг жил гаруйн хугацаа өнгөрөөд байна.

Газрын хэвлий дэх байгалийн баялгийг ирээдүй хойч үеийн иргэдэд тэгш, шударга хүртээх зорилгоор ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Ирээдүйн өв санд хуримтлал бүрдүүлж ирсэн бөгөөд түүхэндээ анх удаа хөрөнгө оруулалтын өгөөжөөр тус сангийн хөрөнгийг арвижуулаад байна.

Ингэснээр Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангуудын хуримтлал 5 их наяд 509.5 тэрбум төгрөг хүрээд байгаа бол ирэх онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос 2 их наяд 186.9 тэрбум төгрөгийг Ирээдүйн өв санд, уул уурхайн салбарын төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн 34 хүртэлх хувьд ноогдох ногдол ашгийн орлогоос 372.9 тэрбум төгрөгийн орлогыг хуримтлалын санд төвлөрүүлэхээр Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн төсөлд тусгаад байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 31.6 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь зарлага 29.6 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 2 их наяд төгрөгийн ашигтай буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь байж төсвийн тусгай шаардлагуудыг бүрэн хангах анхаар байна.

Иймд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 онд төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 онд төсвийн

тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 онд төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Ганхуяг: Хууль санаачлагч болон Монгол Улсын Ерөнхий аудитор нараас асуулт асуух гишүүн байна уу? Нэрсээ авъя. П.Сайнзориг гишүүнээр тасаллаа. Да.Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Да.Цогтбаатар: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Төсөв хэлэлцэж байх үеэр холбогдох яамдуудаас ирж байгаа саналуудыг ер нь нэлээн сайн шүүсэн гэж итгэл үнэмшилтэй суугаад байдаг. Тэгтэл жишээлэхэд Гадаад харилцааны яам, дипломат төлөөлөгчийн газрууд дээр. Жишээ шүү энэ. Америкийн Сан Францискод байгаа төлөөлөгчийн газар яг хамгийн үнэтэй дүүрэг, бүсэд нь ямар ч Монгол Улсын иргэд очоод машин тэргээ тавих боломжгүй тийм зогсоолгүй гэсэн үг. Тэр газарт нь очоод дипломат төлөөлөгчийн газраа байгуулаад өндөр түрээс төлөөд суугаад байдаг.

Тэгэхээр үүнийг жишээлэхэд арай захдуу хэсэг рүү гаргаад, Сан Франциско дотроо арай захдуу хэсэг рүү гаргаад явахад бид тодорхой хэмжээний төсөв хэмнэх боломж байгаа юм.

Тэгээд Гадаад харилцааны яам хэдэн дипломат төлөөлөгчийн газартай билээ. Тэндээс нь энэ мэтчилэнгээр нэг нэг гэхгүй бууруулаад явахад урсгал зардалтай холбоотой асуудлуудыг нэлээн бууруулах боломж байсан. Гэтэл урсгал зардал гээд төсөв өргөн барихдаа 70, 30 гэдэг харьцаагаар өргөн барьсан. 126 гишүүн нь хоёр, гурван тал болж сууж байгаад л ажлын хэсэг гэж нэг хэдэн гишүүн тусдаа гарч сууж байгаад л нэлээн хэдэн өдөр төсөв тойрч маргалдлаа.

Тэгэхээр төсвийн ерөнхийлөн захирагч болгоноор өөрсдөө төсөв дээрээ жоохон цензуртэй, шүүлтүүртэй ханддаг болох юм бол Монгол Улсын төсөв чинь жоохон утгатай болмоор л юм шиг санагдаад байх юм.

Төсвийн ерөнхийлөн захирагч болохоороо өөрсдөө хэмжээ хязгааргүйгээр бялуурна гэж арай байхгүй байлгүй дээ. Сая багш нарын ажил хаялт болоод нэг юм цэгцдээ ороод дуусаж байх шиг байна. Үргэлжлүүлээд эмч нар ажил хаяна шүү гээд Өвөрхангай аймгийн бүсийн оношилгооны төвийнхний үйлдвэрчний эвлэл бичгээ ирүүлсэн. Өглөө Зарлагын хяналтын дэд хороон дээр танилцуулсан. Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлгийн үйлдвэрчний эвлэлээс бас бичиг нь ирсэн. Гэх мэтчилнээр эмнэлгийн асуудал чинь ороод ирэх юм бол төсвөө хэдүүлээ яах вэ гэдэг асуудал давхар үүсэж байгаа.

Тэгэхээр Сангийн сайдаас асуух гээд байгаа нь дахиад зардлуудаасаа өшөө сайн танах боломж байсан уу? Эмнэлгийн ажилчдын зардлын цалингийн

өсөлтийн хүсэлтийн асуудал орж ирэх юм бол Засгийн газар яаж шийднэ гэж төсөөлж байгаа вэ?

Өглөө та гүйцэтгэлтэй холбогдуулж нэлээн ярих шиг болсон. Гүйцэтгэлтэй холбогдуулж ярихаасаа илүүтэйгээр эмч нар үндсэн цалинтай холбоотой асуудлыг нэлээн хөндөж байх шиг байна лээ. Энэ дээр Та эмч нарт нэлээн ойлгомжтой байдлаар тайлбарлаж өгнө үү гэж хүсэж байна.

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Да.Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

Засгийн газар 9 сарын 01-нд 2026 оны төсвийг өргөн барьсан. Өргөн барьсан төсвөөсөө Засгийн газар ийм ийм зардлыг хасах боломжтой гэж хэлэх тодорхойлох ямар ч боломж байхгүй. Нэг төгрөг ч хасах боломж байхгүй.

Өргөн барьсан төсөв маань 2026 оны жилийн төлөвлөгөөг биелүүлэхэд зориулсан төсвийн орлого, зардал байдаг. Өөрөөр хэлбэл хөгжлийн төлөвлөгөөндөө өөрчлөлт орж байж л энэ төсвийн зардал хөдөлнө.

Тэгэхээр төсөв өргөн барьснаас хойш цалин мөнгө, тэтгэвэр, тэтгэмжийн асуудал Их Хурал дээр яригдаж байгаа. Их Хурал дээрээс бидэнд мөн чиглэл өгсөн. Засгийн газар аль зардлаа бууруулах юм. Үүний хариулт бид хоосон зардал гэж байхгүй. Гагцхүү ерөнхийлөн захирагч бүр өөрсдийн 2026 онд хүрэх төлөвлөгөөнөөсөө 10 хувь хойшоо ухарч байна гэсэн үг шүү. 10 хувийг санхүүжүүлэх боломжгүй болж байна гэсэн үг. Ингэж байж цалин, тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдлүүд гарч ирж байгаа юм. Тийм.

Түүнээс биш Засгийн газар өргөн барьсан, төсвийн ерөнхийлөн захирагч нарын хамгийн боломжит доод зардлаар барьсан, өөрөөр хэлбэл 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг биелүүлэх санхүүжилтийг төлөвлөж оруулсан учраас нэмж хасах зардал боломж байхгүй гэдгийг хэлье.

Гүйцэтгэлтэй холбоотой тэр зардлыг М.Санжаадорж дарга тодруулаад ярих уу.

Х.Ганхуяг: 3 номерын микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам М.Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя.

Эрүүл мэндийн даатгалын сантай холбоотой болон одоо явж байгаа санхүүжилттэй холбоотой асуулт асуулаа гэж ойлголоо.

Тэгэхээр манай улс яасан бэ гэхээр өмнө нь төр хариуцах хэсэг гэж байсан. Одоо жишээ нь хүүхдийн өвчлөлийг төрийн албан хаагчийн цалингаар нь буюу

тодорхой цалин авч байгаа хэдэн хүүхэд эмчлэх нь үл хамаараад явдаг. Даатгал нь бүтээмжид суурилсан байсныг одоо нэг худалдан авагчтай загварт оруулаад бүгдийг нь бүтээмжээр нь бид өгдөг болсон юм.

Тэгэхээр Эрүүл мэндийн даатгалын сан Монгол Улсыг эмчилсний төлөө тухайн эмнэлэгт нь өгч байгаа санхүүжилтийн асуудал. Энэ тусдаа асуудал. Энэ сан дээр өр үүсгээд байгаа нь өөрөөр хэлбэл авах ёстой тэр бүтээмжээсээ илүү гэрээ байгуулаад тийм хэмжээний өр өгсөн байгаа.

Хоёр дахь асуудал нь, эмнэлэг дээр яаж энэ мөнгө нь хуваарилагдах вэ, яаж үр ашигтай зарцуулах вэ гэдэг нь тусдаа ондоо асуудал болоод байгаа. Менежментийн эмнэлгийн. Нэг бол Эрүүл мэндийн яам хийх ёстой боловч хийж чадахгүй болоод байгаа. Жишээ нь, сүүлд Азийн хөгжлийн банкны хийсэн судалгаагаар эмчийн илүүдэлтэй гэдэг ийм судалгаа... /минут дуусав/

Х.Ганхуяг: П.Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Сангийн сайдаас л асууя даа. Засгийн газар өргөн барьсан. Энэ дээр Улсын Их Хурлын бүрэн эрх болсон гэж байгаа боловч энэ дээр ажлын хэсэг ажилласан. Дөнгөж энэ саналын томьёоллыг аваад үнэндээ хэлэхэд уншиж амжихгүй байна.

Өнөөдөр 2026 оны ирэх жилийн төсвийг хэлэлцэх гэж байгаа мөртөө ажлын хэсгээс юу оруулж ирж байгааг дөнгөж 3 цаг 55 минутад авлаа. 15 цаг 55 минутад.

Тэгэхээр бид хэд үндсэндээ шийдвэр гаргахад маш их эргэлзээтэй л явж байна. Тэгээд ажлын хэсэг маань сайн ажилласан байх гэж бодоод найдаад л дарах байх, кнопуудыг. Судлах ямар ч бололцоо алга. Ийм байгаа.

Тэгэхээр энэ дээр дүгнэж хэлэх бололцоогүй байгаа учраас Сангийн сайд маань ер нь ирэх жилийн төсөв, иргэд рүү чиглэсэн, иргэдэд ач холбогдолтой ямар өөрчлөлтүүд, чиглэл рүү явж байна? Том зургаараа.

Ажлын байр бий болгох, бизнес буюу бизнесийг дэмжих, хувийн хэвшилд бизнесийн орон зай гаргаж өгөх чиглэлд ямар зүйл явж байна? Монгол Улсын хөгжлийг түргэтгэх дэд бүтцийн төслүүд рүү чиглэсэн хөрөнгө оруулалт ямархуу хэмжээнд онцгойлон чиглэж байна гэдэг зүйл дээр багцлаад хариулаач.

Дараагийн асуудал АМНАТ-ийн асуудал. АМНАТ-ийн асуудлыг ирэх жилд ямар байдлаар оруулж ирж байгаа вэ?

Өнөөдөр гишүүдэд өгөх тэтгэмжийн асуудлыг пүү паа гээд байгаа боловч гуравхан сарын хугацаанд хэрэгжих АМНАТ нь 50 тэрбумын алдагдалд орж байгаа аргачлалыг батлаад байхад хэн ч пүү паа гэж хэлэхгүй байгаа байхгүй юу.

Магадгүй хэвлэлүүдэд хаалтын гэрээнүүдийг тодорхой эрх ашигтай аж ахуйн нэгжүүд нь хийгээд байх шиг байна. Хөндүүлэхгүй байна. Татварын дарга нь хүртэл дүгнээд бичгээ өгөнгүүт хуультай нийцэхгүй байгаа, Ашигт малтмалын хууль дээр дүйцүүлэн АМНАТ тооцох асуудал байхгүй гэдэг бичиг хийж өгөөд долоо хоногийн дараа шууд ажлаасаа халагдаж байна. Шударгаар хэлж байгаа залуучуудыг ажлаас нь халж байна. Энэ Засгийн газар. Ингэж болж байгаа юм уу?

Ирэх жил АМНАТ-аас ямар хэмжээний орлого олно гэж бодсон юм? Ийм заваан хууль зөрчсөн шийдвэрээ үргэлжлүүлэх үү? Сангийн сайд аа.

Хоёрдугаарт, төрийн албан хаагчдын тэтгэвэрт гарахад олгож байгаа нэг удаагийн тэтгэмжийг он дамнуулан олгоно гэж байгаа юм. Энэ дээр ямар өөрчлөлт оруулж ирсэн бэ? Ийм зүйлээр байж болох уу? Үүнийгээ ямархуу байдлаар шийдэж орж ирсэн.

Дээрээс нь бүсчилсэн хөгжлийн асуудал дээр ямар өөрчлөлтүүд байна? Ямар хөрөнгө оруулалтууд байна?

Багш нарын цалин дээр нэг шийдэл хийгээд ороод ирж байгаа байх. Энэ дээр ямар өөрчлөлт орж ирж байгаа юм? Тэгээд татварын реформ хийгдэхээргүй боллоо шүү дээ. Ард иргэд ойлгож байгаа байх. Нөгөө НӨАТ-ын хууль, нөгөө аж ахуйн нэгжийн орлогын албан татварын ч гэдэг юм уу, ер нь явахааргүй боллоо. НӨАТ-ын хуулийн хэрэгжих хугацааг хойшлууллаа. Бизнесийг дэмжинэ гэдэг уянгалж байсан зүйл хийгдэхээ болилоо. Ийм л зүйл болж байна. Тэгээд энэ зүйлээ одоо яг бодитой олон нийтэд хариулаач. Яг юу шийдэж байгаа төсөв бэ? Энэ жил том зургаараа.

Х.Ганхуяг: Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

9 сарын 01-нээс хойш бид төсвөө олон нийтэд маш олон удаа танилцуулсан. Их Хурал дээр ч олон удаа танилцуулсан. Өргөн барихаасаа өмнө ч олон санал авсан байгаа.

Тэгэхээр 2026 оны төсөв гадаад орчин нөхцөл таагүй, тодорхойгүй байдал, энэ бүгд нэлээн эрсдэл өндөр байна гэж үзсэн байгаа.

Тийм учраас төсвийн тэлэлтийг боломжит хэмжээнд хязгаарлаж, өөрөөр хэлбэл дотоодын нийт бүтээгдэхүүний энэ боломжит орон зайг, эдийн засагт үзүүлэх оролцоог хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлд бий болгож орж ирсэн.

Мөн Төсвийн хуулиа дагасан төслүүд дээр ч мөн хувийн хэвшлийг дэмжсэн. Төр, хувийн хэвшлийн түншлэл дээр өөрчлөлт оруулсан. Саяын өөрийн

чинь дурдаад байгаа татварын багц өөрчлөлтөө эхлүүлсэн ийм төсвийг өргөн барьсан. Түүнээс хойш юу болж байгааг Улсын Их Хурал, ажлын хэсэг, Байнгын хорооноос асуух нь зөв.

АМНАТ-тай холбоотой асуудал 12 сарын 31 хүртэл үйлчлэхээр байгаа. Одоо мөн судалгаа хийгдэж байгаа. Шаардлагатай бол наана нь ч зогсоож магадгүй. Магадгүй шүү. 01 сарын 01-нээс хуучнаараа явахаар ингэж төсвийн хуулиа тооцоолж өргөн барьсан байгаа.

Одоо төрийн албан хаагч нарын тэтгэмж, бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалт ямар болж орж ирж байна. Багш нарын цалин, НӨАТ, эдгээр асуудлууд Засгийн газар төсвөө өргөн барьснаас хойш болж байгаа асуудал.

Тийм учраас ажлын хэсгээс асуух нь зөв.

Х.Ганхуяг: П.Сайнзориг гишүүн микрофон өгье.

П.Сайнзориг: Тэгэхээр Х.Ганхуяг дарга аа, танаас асууж болох юм уу? Ажлын хэсгээс асуу гээд байгаа учраас. Тэгээд хэнээс асуух юм бэ? Хэнээс асууж байж шийдвэр гаргах юм бэ?

Сангийн сайд аа, багш нар 6 сар, хаваржингаа ярьсан юм билээ шүү. Олон нийтээсээ санал авсан гээд байгаа мөртөө боловсрол, эрүүл мэндэд хамгийн их санал өгсөн. Бид хүний хөгжлийг дэмжсэн төсөл оруулж ирсэн гэсэн мөртөө боловсрол дээр зөвхөн 2 эмнэлэг барих л зардал оруулж ирээд хөрөнгө оруулалт нь ихэссэн болохоос биш яг шийдэл байгаагүй шүү дээ. Боловсрол дээр мөн адил. Ярьсаар л байсан. Энэ асуудал нь шийдсэн.

Тэгээд энэ саналууд дээрээс ч юм уу ерөнхий багцаас нь дараа нь нэг асуух байх. Одоо жишээ нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцын урсгал зардлыг нэмэгдүүлж байна. Яагаад. Энд ерөөсөө бүдүүн тойм явж байна. Ийм маш хуудуутай, ажлын хэсгийн гишүүд дөнгөж 10-хан минутын өмнө тараасан юмаар өнөөдөр энэ төсөв, 2026 оны төсөв явах гэж байна.

Х.Ганхуяг: Эхлээд Б.Жавхлан сайд хариулаад, би гүйцээгээд хариулъя.

Б.Жавхлан: П.Сайнзориг гишүүний асуултад нэмж хариулъя.

Бид ирэх жил урьд өмнө байгаагүйгээр –

- Боловсролын салбарын хөрөнгө оруулалтыг **5 дахин** нэмэгдүүлж байгаа.
- Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг **3 дахин** нэмэгдүүлж байгаа.

Энэ нь одоо юу ч хийгдээгүй, ямар ч өөрчлөлт байгаагүй гэж Та арай хэлэхгүй байх гэж бодож байна.

Цалингийн хувьд 2026 оны төсөв нэлээн хумигдаж орж ирж байгаа учраас төрийн албан хаагч нар гэхээсээ илүүтэй тэтгэвэр, тэтгэмжийн асуудлуудыг хуульд заасан хэмжээнд нь нэмж оруулж бодлогоо танилцуулсан. Цалингийн асуудал үүнээс хойш яригдаж байгаа гэдгийг хэлье.

Мөн эдгээр хөрөнгө оруулалтуудыг хийснээр манай эрүүл мэнд болон боловсролын салбарын зорилтот түвшин 2026 оны хөгжлийн төлөвлөгөө батлагдсанаас илүү хувь хэмжээгээр ахиж байгаа гэдгийг дахиж хэлье.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсөв нэмэгдээгүй. Та мөн өөрөө оролцож дэмжиж баталсан олон хуулиудаар хэд хэдэн үүргүүд нь нэмэгдэж байгаа. Хэд хэдэн... /минут дуусав/

Х.Ганхуяг: П.Сайнзориг.

П.Сайнзориг. Б.Жавхлан сайд аа, би гар дээрээ авсан саналаар ярьж байгаа байхгүй юу.

Зардал нэмэгдүүлэх санал гэдэг дотор чинь байна. Ийм л байдалтай байна. Тэгээд өнөөдөр төсөв баталчхаад яг хуулийн дагуу явж байсан АМНАТ-ийн аргачлалыг Монгол Улсын эрх ашгийн эсрэг өөрчилж 3 сарын хугацаанд орж ирэх орлогыг бууруулчхаад одоо үүнийг төсвийн жилийн, дуусахаас нь өмнө бас наана нь цуцалж магадгүй гэдэг шийдвэр яриад сууж байна шүү. Нөхөд өө.

Эндээс 50 тэрбум төгрөг. Өөрсдөө Сангийн яамны тооцооллоор нь. Ер нь 22.5 сая тонн нүүрсийг цаашдаа гэрээгээр хийгээд зарна гэж бодох юм бол энэ чинь 150-аад тэрбум төгрөгийн төсөвт орох ёстой орлого үнээсээ шалтгаалаад байгаа шүү. 5 хувийн АМНАТ тооцоход.

Ийм хэмжээний зүйлүүдийг цөөн хэдэн компанид зориулаад энэ боломжийг нь бусад аж ахуйн нэгж эдэлье гэхээр бирж дээр оруулахгүй байгаа юм билээ. Дөрөв, тавхан компанид зориулаад ийм зүйл хийсэн. Ийм байж болох юм уу? Нөхөд өө? Дараа жил битгий ийм алдаагаа давтаад... /минут дуусав/

Х.Ганхуяг: Сүүлийнх нь. Б.Жавхлан сайдын микрофонийг өгье.

Б.Жавхлан: Тодруулаад байгаа учраас хариулахгүй бол болохгүй байх.

П.Сайнзориг дарга аа, тооцоолол дээрээ шаардлагатай бол, тусламж авах хэрэгтэй бол хэлээрэй.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэр зардал нэмэгдүүлэх санал гэж байгаа чинь ажлын хэсгийн санал юм шиг байна. Манай санал биш юм шиг байна.

Тэгэхээр тэндээс хариулах нь зөв байх. Тийм ээ.

Х.Ганхуяг: Баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасны дагуу бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн төслийг хэлэлцээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг санал, дүгнэлтийг нь Төсвийн байнгын хороонд ирүүлснийг Та бүхэнд тараасан.

Төсвийн байнгын хорооны 2025 оны 22 дугаар тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын 2026 онд Төсвийн тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулгыг уншиж танилцуулъя.

Ажлын хэсгийн ахлагч Х.Ганхуяг.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр улс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 онд төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 онд төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын 2026 онд төсвийн тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Төсвийн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 22 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хороон дарга Х.Ганхуягаар ахлуулан 9 гишүүнд бүртгүүлэхээр байгуулсан.

Ажлын хэсгийн 2025 оны 10 дугаар сарын 29, 30, 31, 11 дүгээр сарын 4, 5-ны өдрүүдэд нийт 5 удаа хуралдан ажлын хэсгийн нэгдсэн төсвийн төсөлд тооцоолол хийж ажиллан тодорхой зарчмуудыг баримтлан асуудлыг хэлэлцэж олонхын саналаар шийдвэрлэсэн дараах саналуудыг Та бүхэнд танилцуулж байна. Үүнд:

Нэг. Зардал бууруулах чиглэлээр.

Төсвийн төсөлд тусгагдсан урсгал зардалд дүн шинжилгээ хийж, үүнд үндэслэн –

- орон нутгийн нийслэл орохгүй төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлыг 6 хувиар,
- бусад төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал зардлыг 12.8 хувиар бууруулах.

Мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн зарим урсгал зардлыг 2025 оны түвшинд барих. Түүнчлэн тэвчиж болох зарим зардлуудыг хойшлуулах. Хөрөнгө оруулалтын төслүүдийн хувьд улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэйгөө уялдаагүй зарим төслүүдийг хасах. 2027 он болон дараа онууд руу шилжих төслүүдийн санхүүжилтийг тодорхой хувиар бууруулах зарим салбарын тоног

төхөөрөмжийн зардлыг 50 хувиар бууруулах. НҮБ-ын COP17 хурлын барилга, байгууламжийн санхүүжилтийг бууруулах зэрэг зарчим баримталлаа.

Хоёр. Зардал нэмэгдүүлэх чиглэлээр.

Боловсролын салбарын гүйцэтгэлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, эмч, эмнэлгийн байгууллагын ажиллагсдын цалин, төрийн өмч, эрдэм шинжилгээний байгууллагын ажилчдын цалин болон өндөр насны тэтгэвэр, халамжийн тэтгэврийг нэмэгдүүлэхээр санал оруулж байна.

Түүнчлэн ажлын хэсэгт Улсын Их Хурлын гишүүд болон төрийн болон төрийн бус байгууллагуудаас албан бичгээр ирүүлсэн санал тус бүрийг судалж хуралдаанаараа хэлэлцсэн болно.

Ажлын хэсгээс шийдвэрлэсэн дээрх асуудалтай холбоотой саналын томьёолол, тэдгээрийн хавсралтыг Та бүхэнд хүргүүлээ.

Байнгын хорооны гишүүд ээ,

Ажлын хэсгийн санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгээс төсвийн төсөлтэй холбогдуулан ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Саналыг Та бүхэнд танилцуулъя.

1.Зардал бууруулах санал:

1.1.Урсгал зардал бууруулах:

- Төрийн албан хаагчдын цалин хөлс, Хүүхдийн мөнгөн тэтгэмж, Нийгмийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Боловсролын салбарын гүйцэтгэлийн санхүүжилт, улсын төсвөөс санхүүжих эрүүл мэнд, боловсролын байгууллагууд, гамшиг, ослоос хамгаалах, эрэн хайх, аврах ажиллагааны зардал, Засгийн газрын зээлийн үйлчилгээний хүүгийн зардал, гадаад зээл, тусламжаас санхүүжих урсгал зардал, 100 хувь өөрийн орлогоос санхүүжих зардлыг хөндөхгүйгээр аймгуудын урсгал зардлыг **6.0 хувиар**, бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлыг **12.8 хувиар** бууруулж, нийт **411,447.6 сая** төгрөгөөр;
- Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “**1,542,428.4**” гэснийг “**1,235,328.4**” гэж холбогдох шийдвэрийн хамт өөрчлөн, гадаад зээллэгийн ашиглалтыг **307,100.0 сая** төгрөгөөр;

- Улсын Их Хурлын гишүүдийн зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг **88.9 сая** төгрөгөөр;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын “Эрчим хүчний экспортыг дэмжих нэгж”-ийн урсгал зардлыг **2,588.6 сая** төгрөгөөр;
- Ойн газрын урсгал зардалд ойжуулалтын зардалд зориулж **44,161.7 сая** төгрөг тусгагдсан тул Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны урсгал зардалд давхар тусгагдсан ойжуулалтын хөтөлбөрийн зардлыг **5,023.5 сая** төгрөгөөр;
- Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын төсвийн багцын аялал жуулчлалын чиглэлийн хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасыг **8,000.0 сая** төгрөгөөр;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцын “Шинэ хоршоо хөтөлбөр”-ийн 2026 оноос шинээр олгохоор тооцсон зээлийн хүүгийн татаасыг **22,000.0 сая** төгрөгөөр;
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцын Зээлийн батлан даалтын сангийн дүрмийн санг нэмэгдүүлэхэд тусгагдсан санхүүжилтийг **25,000.0 сая** төгрөгөөр;
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн санхүүжилтийг **10,000.0 сая** төгрөгөөр;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын төрийн албан хаагчийг мэргэшүүлэх зардалд зориулж Удирдлагын академид олгодог санхүүжилтийг **4,636.6 сая** төгрөгөөр;
- 2026 оны төсвийн жилд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Шадар сайд нарын ажлын алба болон бүх яамдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардал шинээр тусгагдсаныг хасаж, нийт **10,000.0 сая** төгрөгөөр;
- Хархорум хотын Захирагчийн ажлын албаны урсгал зардлыг 2025 оны түвшинд тооцож **2,840.0 сая** төгрөгөөр;
- Орон нутгаас бусад бүх төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал засварын зардлыг **40,000.0 сая** төгрөгөөр;
- Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын их засварын зардлыг Төсвийн шатлал хоорондын тооцооллыг оруулснаар тооцож **40,000.0 сая** төгрөгөөр;
- Үндэсний аудитын газрын урсгал зардлыг 2025 оны түвшинд тооцож **4,916.8 сая** төгрөгөөр;
- Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын эрдэм, шинжилгээ судалгааны ажлын зардлыг **916.8 сая** төгрөгөөр;
- Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцын судалгаа шинжилгээний зардлыг **1,510.2 сая** төгрөгөөр;
- Шадар сайдын төсвийн багцын эрдэм шинжилгээ, судалгааны зардлыг **9,000.0 сая** төгрөгөөр;
- Орон нутгийн авто замын сангийн санхүүжилтийг төсвийн шатлал хоорондын харилцаагаар тооцсон дүнгээр буюу **60,000.0 сая** төгрөгөөр;
- Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Улсын ерөнхий прокурор болон Шадар сайдаас бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардлыг 2025 оны

түвшинд тооцож нийт **6,816.7 сая** төгрөгөөр буюу нийт **971,885.7 сая** төгрөгөөр бууруулах.

1.2.Хөрөнгийн зардал бууруулах:

- Төслийн 2 дугаар хавсралтын Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцийн 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой болон боловсрол, эрүүл мэнд, онцгой байдал, батлан хамгаалах, соёл, улсын бүртгэл, шүүх шинжилгээ, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллага, сонгуулийн тоног төхөөрөмжөөс бусад шинээр хэрэгжүүлэх тоног төхөөрөмжийн санхүүжилтийг **50 хувиар** буюу **62,930.4 сая** төгрөгөөр, 2026 онд дуусах хөрөнгө оруулалтын төслүүдийг хөндөхгүйгээр, 2027 он болон түүнээс цааших онуудад шилжих хөрөнгө оруулалтын төслүүдийн 2026 онд санхүүжих дүнг зам тээврийн салбарынхыг **17.2 хувиар** буюу **77,367.8 сая** төгрөгөөр, бусад салбарынхыг **15 хувиар** буюу **127,010.7 сая** төгрөгөөр, УТ2601300905 төслийн кодтой “Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцийн 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой барилга байгууламж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **150,000.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацааг 2026-2027 он гэж өөрчлөн, 2026 онд санхүүжих дүнг **50,000.0 сая** төгрөгөөр, уг саналуудад давхардаагүй Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлж нийт **14,529.3 сая** төгрөгөөр **Хавсралт 1-д** тусгагдсаны дагуу нийт **331,838.2 сая** төгрөгөөр бууруулах.

2.Зардал нэмэгдүүлэх санал:

2.1.Урсгал зардал нэмэгдүүлэх санал:

- Боловсролын салбарын гүйцэтгэлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх хүрээнд багш нарын үндсэн цалинг 2026 оны 01 дүгээр сарын 01-ээс **742.0 мянган** төгрөгөөр, 11 дүгээр сарын 01-ээс **2,800.0 мянган** төгрөгт хүргэхээр тооцож Боловсролын сайдын урсгал зардлыг **518,620.2 сая** төгрөгөөр;
- Эмч, эмнэлгийн байгууллагын ажиллагсдын цалинг **15 хувиар** нэмэгдүүлэхэд зориулж Эрүүл мэндийн сайдын урсгал зардлыг **190,300.0 сая** төгрөгөөр;
- Төрийн өмчийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ажилчдын цалинг **15 хувиар** нэмэгдүүлэхэд зориулж Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын урсгал зардлыг **9,794.9 сая** төгрөгөөр, Боловсролын сайдын урсгал зардлыг **925.7 сая** төгрөгөөр, нийт **10,720.6 сая** төгрөгөөр;
- Ахмад настны тэтгэврийг 6 хувиар нэмэгдүүлэхээр төсөлд тусгагдсаныг инфляцын түвшинтэй уялдуулан тооцож **8.6 хувь** болгон нэмэгдүүлэхэд

зориулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын урсгал зардлыг **145,000.0 сая** төгрөгөөр;

- Халамжийн тэтгэврийг 6 хувиар нэмэгдүүлэхээр төсөлд тусгагдсаныг инфляцын түвшинтэй уялдуулж тооцож **8.6 хувь** хувь болгон нэмэгдүүлэхэд зориулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын урсгал зардлыг **19,500.0 сая** төгрөгөөр;
- Монгол Улсын иргэний дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүүхэд залуучуудын суралцах тэгш боломжийг хангах, дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцахад дэмжлэг үзүүлэх зорилгоор олгодог “Илгээлт-2100” хөтөлбөрийн санхүүжилтийг **33,000.0 сая** төгрөгөөр;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын урсгал зардлыг **2,446.8 сая** төгрөгөөр;
- Хүний эрхийн сурах бичигт зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг **231.9 сая** төгрөгөөр;
- Шатахууны нөөцийн агуулах, дэд бүтэц бүрдүүлэх хүүгийн татаас, хяналтын системийг бүрдүүлэх зардалд **20,000.0 сая** төгрөгөөр буюу нийт **939,819.5 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.Хөрөнгийн зардал нэмэгдүүлэх санал:

- Магадлалын ерөнхий дүгнэлтэд хийсэн аудитын дүгнэлтийг үндэслэж хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэхтэй холбогдуулан эрүүл мэнд, боловсролын салбарын зарим төсөл, арга хэмжээг төсөлд шинээр тусгах, санхүүжих дүнг нэмэгдүүлэх мөн Хөгжлийн бодлогын зарим баримт бичгүүд, бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгагдсан авто зам, гүүр, эрчим хүч, иргэдийн орон нутагтаа ажиллаж, амьдрах, бизнес эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлсэн өрсөлдөх чадвартай бүсүүдийг бий болгох зорилт, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор хөрөнгийн зардлыг **363,904.4 сая** төгрөгөөр буюу **Хавсралт 2-т** тусгагдсаны дагуу нэмэх.

3.Орлого нэмэгдүүлэх санал:

Татварын зарлагыг бууруулах буюу нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэрэгжих хугацааг хойшлуулж, үүнтэй уялдуулан татварын орлогыг **375,000.0 сая** төгрөгөөр, мөн төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг 2025 оны төсөвлөсөн дүнд хүргэж **5,000.0 сая** төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх.

4.Орлого бууруулах санал:

Агаарын навигацын үйлчилгээний хураамжийн орлогоос төсөвт төвлөрүүлэхээр тооцсон дүнг **40,000.0 сая** төгрөгөөр, мөн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогыг **10,000.0 сая** төгрөгөөр тус тус бууруулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Д.Батбаяр, Ж.Алдаржавхлан, Р.Батболд, Б.Заяабал, Д.Жаргалсайхан, Х.Жангабыл, П.Мөнхтулга, Г.Тэмүүлэн. Цаашид “Ажлын хэсэг” гэх.

Санал хураалтад бэлтгэе. Гишүүд ээ.

Ж.Алдаржавхлан гишүүн ороогүй байна, Д.Батбаяр гишүүн ороогүй байна, Ж.Батжаргал гишүүн ороогүй байна, Ж.Батсуурь гишүүн ороогүй байна, С.Болормаа гишүүн ороогүй байна, Гомбын Ганбаатар гишүүн ороогүй байна, П.Ганзориг гишүүн ороогүй байна, Ц.Даваасүрэн гишүүн ороогүй байна, Д.Жаргалсайхан гишүүн ороогүй байна, З.Мэндсайхан гишүүн ороогүй байна, Ч.Номин гишүүн ороогүй байна, Д.Пүрэвдаваа гишүүн ороогүй байна, П.Сайнзориг гишүүн ороогүй байна, Д.Үүрийнтуяа гишүүн ороогүй байна, Да.Цогтбаатар гишүүн ороогүй байна, Б.Чойжилсүрэн гишүүн ороогүй байна, Д.Энхтүвшин гишүүн ороогүй байна, Гомбын Ганбаатар гишүүн ороогүй байна, Ц.Даваасүрэн гишүүн ороогүй байна, П.Ганзориг гишүүн ороогүй байна, Д.Энхтүвшин гишүүн ороогүй байна, Д.Пүрэвдаваа гишүүн ороогүй байна, Б.Чойжилсүрэн гишүүн ороогүй байна. Тийм. Алив дахиад шалга даа. Болсон уу? Боллоо. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдлээ.

Хоёр. Төсвийн тэнцэлд нөлөөлөхгүй зохицуулалтын санал.

1.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601100108 төслийн кодтой “Татварын мэдээллийн системийн дэд бүтэц, серверийн болон татварын албадын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **23,026.9 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **19,706.6 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр төслийн 2 дугаар хавсралтад “Чойбалсан нисэх буудал /Аэродром/-ын хөөрч, буух зурвас, шинэчлэх /Дорнод, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг **59,120.0 сая** төгрөг, санхүүжих дүн **19,706.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Алив Б.Гандулам зөвлөх хэлчих. Дэглэмээ хэлчих.

Төсвийн дэг өөр шүү. Та өөрийнхээ дэгээ андуураад байх шиг байна. Алив Б.Гандулам зөвлөх дэгийнхээ юмыг уншаад өгчих. Тэгэх үү. Битгий орж бужигнуулаад бай.

Б.Гандулам: Сайн байна уу? Төсвийн байнгын хороо. Б.Гандулам. Асуултад хариулъя.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлээр төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг зохион байгуулдаг. 71.4 дээр бусад Байнгын хороод болон Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, Төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн эрхлэх асуудлынхаа хүрээнд асуудлыг хэлэлцэж болно гэсэн байгаа.

Энэ дагуу өнөөдөр Төсвийн байнгын хороо 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг хийж байгаа.

71.5-аар бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд гишүүн нам, эвслийн бүлэг, төрийн аудитын төв байгууллага саналаа зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт гаргана гэсэн байгаа.

71.6 дээр бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо энэ хуулийн 71-ийн 5-д заасан санал тус бүрээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг санал, дүгнэлтийн хамт Төсвийн байнгын хорооны хуралдаанд хүргүүлнэ гэсэн байгаа.

71.9-д Төсвийн байнгын хороо энэ хуулийн 71.6-д заасан болон Төсвийн байнгын хорооны гишүүд, мөн түүнчлэн төсөвтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч төрийн аудитын төв байгууллага, нам, эвслийн бүлгээс гарсан санал нэг бүрийг хэлэлцэж, ил санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж нэгдсэн хуралдаанд оруулна гэсэн заалттай.

Х.Ганхуяг: Ийм байна шүү. Санал хураалт.

Ж.Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Уучлаарай. Гишүүд ээ. Би бас юм тодруулах гэж байгаад. Саяын саналын томьёоллыг дэмжиж санал өгөх байсан юм. Тэгсэн чинь амжсангүй. Саяын санал хураалтыг хүчингүй болгоод дахин санал хураалт явуулж өгөх горимын санал гаргаж байна.

Х.Ганхуяг: Саяын явуулсан санал хураалтыг хүчингүй болгохоор санал хураалт явуулъя. Санал хураалтад бэлдээрэй гишүүд ээ.

Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдлээ. 61.5 хувиар.

2.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **40,000.0** сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **3,068.7 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Цэцэрлэгийн барилга 150 ор /Дорнод, Дашбалбар сум/, хэрэгжих

хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **6,137.4 сая** төгрөг, санхүүжих дүн **3,068.7 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **40,000.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **2,231.9 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Цэцэрлэгийн барилга 150 ор /Дорнод, Матад сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **4,463.6 сая** төгрөг, санхүүжих дүн **2,231.9 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

65.4 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2102900758 төслийн кодтой “Гандангийн дэнж” шинэ аялал жуулчлалын бүсийн зураг төсөв, барилгын ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо/, хэрэгжих хугацаа 2022-2027 он, төсөвт өртөг **23,484.9 сая** төгрөг, санхүүжих дүн **6,130.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **3,090.0 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Хүүхэд залуучуудын “Зүүн наран” хүрээлэн /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **9,271.9 сая** төгрөг, санхүүжих дүн **3,090.0 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

69.2 хувиар дэмжигдлээ.

5.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804408 төслийн кодтой “Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7 км /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг **186,000.6 сая** төгрөг, санхүүжих дүн **40,000.0 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **1,719.0 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Монголын товчоо цогцолборын барилгын гадна тохижилтийн ажлын нэмэлт ажил /Хэнтий, Дэлгэрхаан сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **685.0 сая** төгрөг”, “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Баян-Овоо сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн **434.1 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг, “Уурын зуухны барилгын шугам сүлжээний засвар /Хэнтий, Мөрөн сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **600.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус нэмж тусгах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

65.4 хувиар дэмжигдлээ.

6.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг **202,137.9 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **23,950.1 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **4,080.2 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Баян-Адрага сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн **404.3 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Бэрх тосгон/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн **651.8 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, “Шихихутаг, нууц товчоо түүхэн аялал жуулчлалын барилгын нэмэлт санхүүжилт” /Хэнтий, Норовлин сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **641.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, “Их хуралдай цогцолборын барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Биндэр сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **238.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг, “Соёлын төвийн барилга, /Хэнтий, Батширээт сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **436.0 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг, “Соёлын төвийн барилга, /Хэнтий Цэнхэрмандал сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **1,707.9 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус нэмж тусгах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

65.4 хувиар дэмжлээ.

7.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800893 төслийн кодтой Замын-Үүд талаас Сайншанд чиглэлийн 16 км хатуу хучилттай замын хэсэгчилсэн их засвар /Дорноговь/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **22,268.3 сая** төгрөг, санхүүжих дүн **10,020.8 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төслөөс хасаж, энэ эх үүсвэрээр “Саран хөхөө дуулалт театр төсөвт өртөг **15,800.0 сая** төгрөг, санхүүжих дүн **8,300.3 сая** төгрөг төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдлээ. 65.4 хувиар.

8.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2003400774 төслийн кодтой Байгалийн түүхийн музейн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/, хэрэгжих хугацаа 2020-2026 он, төсөвт өртөг **130,618.4 сая** төгрөг, санхүүжих дүн **51,982.6 сая** төгрөг

гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг аудитын магадлалын ерөнхий дүгнэлтийг үндэслэн **94,691.1 сая** төгрөгөөр нэмэгдүүлж, санхүүжих дүнг **36,000.0 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Байгалийн түүхийн музейн үзүүлэг дэглэлт, үзмэрийн интерьерийн зураг, цуглуулга, үзмэрийн тоноглол, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Хан-Уул/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **178,368.0 сая** төгрөг, санхүүжих дүн **36,000.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар дэмжигдсэн байна.

9.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцад тусгагдсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Цөлжилттэй тэмцэх тухай" суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлын үед зохиогдох соёл, урлагийн арга хэмжээний зардлыг **4,000.0 сая** төгрөгөөр бууруулж, мөн дүнгээр Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын багцын Кино урлагийг дэмжих сангийн санхүүжилтийг нэмэгдүүлэх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар дэмжигдлээ.

10.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602900572 төслийн кодтой “Үерийн хамгаалалтын далангийн 2, 3 дугаар ээлжийн байгууламж /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг нь **10,407.8 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **3,122.4 сая** төгрөг” гэсэн арга хэмжээг хасаж, энэ эх үүсвэрээр “Шинэ суурьшлын бүсийн дэд бүтцийн ажил /Архангай Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **25,651.2 сая** төгрөг, санхүүжих дүн **3,122.4 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

69.2 хувиар дэмжигдлээ.

11.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808722 төслийн кодтой “Өгийнуур - Мянганы замын хэвтээ тэнхлэг чиглэлийн хатуу хучилттай авто зам, 28.5 км /Хангайн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг нь **43,603.2 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **12,989.4 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний 2026 онд санхүүжих дүнг **4,853.3 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж /Архангай, Эрдэнэбулган төв сум, 5-р баг, Наранбулаг/ хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **13,263.2 сая** төгрөг, санхүүжих дүн **3,000.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг болон “Тайхар чулуу хүртэлх 3.2 км хатуу хучилттай авто зам /Архангай, Ихтамир сум/, хэрэгжих

хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **5,853.3 сая** төгрөг, санхүүжих дүн **1,853.3 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус нэмж тусгах.

Санал давхацсан байна уу? Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй.

12.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **40,000.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **2,400.0 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Ахмадын сувиллын иж бүрэн засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 19-р хороо/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **1,300.0 сая** төгрөг, “Хиймэл оюун мэдээллийн технологийн “Google”-ийн хөтөлбөр хэрэгжүүлэх лаборатори сургуулийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 2-р сургууль/ хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **1,100.0 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус нэмж тусгах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар дэмжигдсэн байна.

13.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400293 төслийн кодтой “Тусгай зориулалтын барилга байгууламж, дэд бүтэц /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **26,586.5 сая** төгрөг, санхүүжих дүн **7,976.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **600.0 сая** төгрөгөөр, УТ2601400293 төслийн кодтой “Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн ажилчдын орон сууцны барилга, 50 айл /Говь-Алтай, Есөнбулаг сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг **5,949.2 сая** төгрөг, санхүүжих дүн **2,082.1 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **600.0 сая** төгрөгөөр, УТ2601400232 төслийн кодтой “Тусгай зориулалтын төвийн барилга /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **20,132.1 сая** төгрөг, санхүүжих дүн **9,000.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **300.0 сая** төгрөгөөр буюу нийт **1,500.0 сая** төгрөгөөр хөрөнгийн зардлыг бууруулж, Батлан хамгаалах яамны харьяа Үндэсний батлан хамгаалахын Их сургуулийн урсгал зардлыг **1,500.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Ажлын ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

69.2 хувиар дэмжигдлээ.

14.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402901667 төслийн кодтой “Ховд хотын ундны усны хоёр дахь эх үүсвэр /Ховд, Жаргалант сум/, хэрэгжих хугацаа

2024-2028 он, төсөвт өртөг **38,071.2 сая** төгрөг, санхүүжих дүн **5,825.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **4,500.0 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Сум, багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Увс, Завхан, Ховд, Говь-Алтай/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **4,500.0 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

65.4 хувиар дэмжигдлээ.

15.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2102900392 төслийн кодтой “Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтэц /Архангай/, хэрэгжих хугацаа 2022-2027 он, төсөвт өртөг **26,964.8 сая** төгрөг, санхүүжих дүн **6,118.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **1,608.5 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Нийтийн ариун цэврийн байгууламж бүхий барилгын гадна замын авто зогсоол /Архангай, Цэнхэр сум/”, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **1,608.5 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

65.4 хувиар дэмжигдлээ.

16.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүдийн лабораторийн багаж, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **32,544.4 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **1,200.0 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Кембриджийн хөтөлбөр хэрэгжүүлэх лаборатори сургуулийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн” /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 166 дугаар сургууль/, хэрэгжих хугацаа **1,200.0 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

65.4 хувиар дэмжигдлээ.

17.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601100108 төслийн кодтой “Татварын мэдээллийн системийн дэд бүтэц, серверийн болон татварын албадын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн **23,026.9 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **3,320.3 сая** төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Газрын тос боловсруулах үйлдвэрийн цахилгаан хангамжийн 110кВ-ын ЦДАШ, 110/35/10кВ-ын Ширээт дэд станц, хэрэгжих хугацаа 2026-2028 он, **16,837.9 сая** төгрөг, санхүүжих дүн **3,320.3 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

65.4 хувиар дэмжигдлээ.

Гурав. Төсвийн тэнцэлд нөлөөлөхгүй санал.

1.Төсвийн захирагч хооронд шилжүүлэх:

1.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын Сэлэнгэ аймгийн Мандал сумын хүүхдийн ордны үйл ажиллагааг орон нутагруу шилжүүлэх замаар Сэлэнгэ аймгийн суурь зардлыг **421.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

57.7 хувиар дэмжигдлээ.

2.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр өөрчлөх санал:

1.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400557 төслийн кодтой “Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаанд нэн шаардлагатай тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/” гэсэн төсөл, арга хэмжээний “үйл ажиллагаанд нэн шаардлагатай” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

65.4 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400570 төслийн кодтой “Соёл, спорт, аялал жуулчлалын салбарын төрийн өмчийн барилга байгууламжийн хүчитгэл, их засвар /Улсын хэмжээнд/” гэсэн төсөл, арга хэмжээний “хүчитгэл,” гэснийг “сэргээн засварлах” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

65.4 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602900811 “Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /Архангай, Өвөрхангай/” гэсэн төсөл, арга хэмжээний “Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” гэснийг “Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар дэмжигдсэн байна.

3.Төслийн 1 дүгээр хавсралтын талаарх санал:

1.Төслийн 1 дүгээр хавсралтын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрт “16.1.3.4 Цагаатгал, нөхөн олговортой холбоотой хууль тогтоомжийн нэгдмэл байдлыг хангах, Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024 он, Суурь түвшин: 25, Зорилтот түвшин: “40” гэсэн дэд заалт, “16.1.3.5 Их, дээд сургууль болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад хэлмэгдүүлэлт, түүний хор уршгийг таниулах чиглэлээр сургалтад хамрагдсан сурагчдын хувь. Хэмжих нэгж: Хувь, Суурь он: 2024 он, Суурь түвшин: “Т”, Зорилтот түвшин: “Т+10 %” гэсэн дэд заалт тус тус нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

65.4 хувиар дэмжлээ.

4.Засгийн газрын 2026 оны төсвийн жилд шинээр үүсгэх өрийн хэмжээнд өөрчлөлт оруулах санал:

1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг буюу “Өрийн удирдлагын тухай хуулийн 28¹.1-д заасан зориулалтаар гаргах аймгийн үнэт цаасны дээд хэмжээг **150,000.0 сая** төгрөг хүртэл” гэсний “аймгийн” гэснийг “аймаг, нийслэлийн” гэж, “**150,000.0 сая** төгрөг” гэснийг “**425,000.0 сая** төгрөг” гэж, холбогдох шийдвэрийн төслийн хамт өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

69.2 хувиар дэмжигдлээ.

Гишүүнээс ирсэн бичгээр ирсэн санал дээр “аймаг” гэснийг “аймаг, нийслэлийн” гэж, “150” гэснийг “425” гэж, “Алсын хараа-2050” гэж.

Санал гаргасан Улсын Их хурлын гишүүн П.Сайнзориг.

Дөрөв. Зарчмын зөрүүтэй саналын томьёололд нийцүүлэн хуулийн төсөлд өөрчлөлт оруулах санал.

1.Төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан дэмжигдсэн саналуудыг төсвийн тооцоололд бүрэн тусгаж, зарчмын зөрүүтэй дэмжигдсэн саналыг нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг тусгах, үүнтэй уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нарын зарцуулах урсгал болон хөрөнгийн зардал, төвлөрүүлэх орлогын хэмжээ, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ, Нийгмийн даатгалын сангийн болон Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагад нөлөөлөх өөрчлөлт, мөн төслүүдийн зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлж өөрчлөх, үг хэллэг, нэр томьёог жигдлэх засварыг

хийх, мөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төслийн код өгөх, дугаар, эдийн засгийн ангилал, хэрэгжих хугацааг саналын томьёололд нийцүүлэн өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

65.4 хувиар дэмжигдлээ.

2.Монгол Улсын 2026 оны төсвийн тооцоололд өөрчлөлт оруулах болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн хэлэлцүүлгийн явцад гарсан саналын томьёололтой холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг үндэслэн холбогдох хуулийн төслийг боловсруулж Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

61.5 хувиар дэмжигдсэн байна.

Бусад Байнгын хороод болон Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос ирүүлсэн саналын томьёоллоор санал хураалт явуулж эхэлье.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал.

1.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг **202,137.9 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **23,950.1 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **404.3 сая** төгрөгөөр бууруулж энэ эх үүсвэрээр “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Баян-Адрага сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн **404.3 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал. Санал хураалт. /алх цохив/

Энэ чинь гишүүний саналаар хурааж байгаа. Тэгэхээр энэ санал дэмжигдэхгүй гэсэн үг.

Би Байнгын хороон дээр энэ санал нь дэмжигдээгүй юм гэж хэлж байгаа боловч энэ гишүүний гаргасан саналыг л хурааж байна гэсэн үг.

2.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804408 төслийн кодтой Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179.7 км /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум//, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг **186,000.6 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **40,000.0 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний

санхүүжих дүнг **434.1 сая** төгрөгөөр бууруулж энэ эх үүсвэрээр “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Баян-Овоо сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн **434.1 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Үүнийг танилцуулъя. Энэ нөгөө ажлын хэсэг дээр хураагдаад дэмжигдсэн саналыг хураагаад дэмжсэн шүү дээ. Ажлын хэсэг дээр. Сая бид дахиад хураагаад Байнгын хороо дэмжсэн. Энэ чинь дахин дахин уншаад дэмж санал хураагаад байх шаардлагагүй байх. Тийм ээ. Сая П.Сайнзориг бусад гишүүдийн дэмжигдсэн саналыг бид танилцуулаад л санал хураахгүй явуулчхаж байгаа шүү дээ. Санал хураалт. /алх цохив/

Дэмжихгүй юм байна гэсэн үг.

7.7 хувь дэмжигдсэнгүй.

3.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг **202,137.9 сая** төгрөг, 2026 онд санхүүжих дүн **23,950.1 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **651.8 сая** төгрөгөөр бууруулж энэ эх үүсвэрээр “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий, Бэрх тосгон/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөв өртөг болон санхүүжих дүн **651.8 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй.

4.Боловсрол, Эрүүл мэнд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбараас бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлыг 0.37 хувиар буюу **29,204.3 сая** төгрөгөөр бууруулж, төслийн 2 дугаар хавсралтын УТ2603800007 төслийн кодтой, “Сонгуулийн ерөнхий хорооны тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **41,720.4 сая** төгрөг, санхүүжих дүн **12,516.1 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг мөн дүнгээр нэмэгдүүлж, хэрэгжих хугацааг 2026-2026 он гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй.

5.Төрийн албан хаагчдын өндөр насны тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн буцалтгүй тусламж болох 36 хүртэлх сарын үндсэн цалинтай нь тэнцэх

хэмжээний тэтгэмжийн зардалд тусгагдсан санхүүжилтийг **178,089.9 сая** төгрөгөөр нэмэгдүүлж, уг эх үүсвэрийг төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийн урсгал зардлын бараа, үйлчилгээний бусад зардлыг **7.83 хувиар** буюу **178,089.9 сая** төгрөгөөр бууруулах замаар бүрдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа.

А.Ариунзаяа гишүүн тайлбар хэлье.

А.Ариунзаяа: Эрхэм Төсвийн байнгын хорооны гишүүд ээ, төсөв өргөн барихад төрийн албан хаагчдын энэхүү тэтгэмжтэй холбоотой хууль зөрчсөн байна гэдэг асуудлыг дэвшүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороон дээр албан ёсоор тогтоол гаргаж хууль зүйн дүгнэлт гаргуулсан.

Хууль зүйн дүгнэлтээр төрийн албан хаагчдыг өндөр настны тэтгэвэрт гарахад төрөөс олгодог нэг удаагийн 36 сар хүртэлх тэтгэмжийг 50 хувь бууруулж эх үүсвэрийг нь тавьсан. 2027 он руу 50 хувийг нь шилжүүлсэн эл явдал нь хууль зөрчсөн байна, эрх зүйн үр дагавартай байна гэдэг ийм дүгнэлтийг ирүүлсэн байгаа.

Төрийн албаны тухай хуулийн 9.2 дахь хэсэгт төрийн албаны зардлыг бууруулах талаар төрөөс авах арга хэмжээ нь аливаа олговрыг зогсоох, түр зогсоох, бууруулах үндэслэл болохгүй гэж хуульчилсан байгаа. Энэ хуулийн заалт хэвээрээ үйлчилж байгаа.

Тэгэхээр энэ заалтыг нэг талдаа зөрчиж байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт болон тус хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дахь хэсэгтээ мөн зөрчил үүсэхээр байна гэдгийг дүгнэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 6.4.8-д төсвийг зохистой удирдаж, өр авлага үүсгэхгүй байх зарчмыг хуульчилсан байдаг.

Тэгэхээр энэ бол ирэх он руугаа өр үүсгэж байна гэсэн үг.

Мөн тус хуулийн 70.5 дээр өр авлага үүсгэсэн албан тушаалтанд албан тушаалаас нь чөлөөлөх үндэслэл болно гэсэн энэ заалт бас эрх зүйн үр дагавартай байна гэдгийг заагаад өгсөн байгаа.

Тэгэхээр Төрийн байгуулалтын байнгын хороон дээр дэмжигдсэн саналыг Та бүхнийг дэмжиж хуулийн зөрчлийг арилгаж өгөхийг хүсэж байна. Бид аливаа хууль тогтоомжийг өөрсдөө мөрдөж байх үүргийг хүлээж байгаа хүмүүс шүү гэдгийг бас энэ ташрамд хэлмээр байна.

Х.Ганхуяг: М.Санжаадорж дарга нэг тайлбар хэлье. Энэ асуудал дэмжигдэхээр ямар асуудал үүсэх вэ? Танагдахаар ямар асуудал үүсэх вэ? 3 номер.

М.Санжаадорж: Сангийн яам. М.Санжаадорж.

Саяын зарчмын зөрүүтэй саналтай холбоотойгоор нэмэлт тайлбар хүргүүлье.

Сангийн яамны зүгээс жил бүрийн улсын төсвийг төлөвлөхдөө тухайн төсвийн жилдээ регистрийн дугаараараа тэтгэвэрт гарах насны тоонд насанд хүрч байгаа хүмүүсийн тоонд үндэслэж төсвийг төлөвлөдөг.

Түүнээс биш тухайлан иргэнийг М.Санжаадорж та тэтгэвэрт гарах уу гэж асуудаггүй. Өөрөөр хэлбэл Сангийн яам илүү удаан хугацаанд ажиллуулахыг дэмждэг.

Нөгөө талдаа яг энэ агуулгаараа тухайн албан хаагчид үүнийг тэтгэвэрт гарах настайгаа, тэтгэврийн дээд настайгаа уяж тооцоолж ажилладаг. Өөрөөр хэлбэл хөдөө орон нутагт 5 жил тутмын тэтгэмжээ жишээ нь 2027 онд аваад тухайн жилдээ тэтгэвэртээ гарна гэсэн тооцоотойгоор ажиллаж байгаа ийм хүн байгаа. Энэ хүмүүсийн хувьд одоо ингээд тэтгэврийн 36 сар нь 18 сар болж байна гэдэг буруу ойлголтоос болоод энэ хүний хувийн шийдвэр гаргахад нь нөлөөлж байгаа асуудал засаг дээр үүсээд байгаа.

Тэгэхээр бид энэ арга хэмжээг өмнө нь яаж авч хэрэгжүүлж байсан гэхээр энэ нь өөрөө урсгал зардал маань дотроо зохицуулалт хийх эрх бүрэн байж байдаг. Энэ агуулгаар Засгийн газрын хувьд энэ арга хэмжээг аваад хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн.

Түүнчлэн төсөв батлагдсантай холбоотойгоор Улсын Их Хурлын тогтоол гаргах бол энэ тогтоол дээр бид энэ талаар чиглэл авахаар ажиллаж байгаа.

Мөн өмнөх Өргөдлийн байнгын хороон дээр яригдсаны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр энэ асуудал яригдсан. Энэ дагуу үүнийг нарийвчлан зохицуулах асуудлыг журамлахаар Засаг дээр бас яригдаж байгаа.

Тэгэхээр энэ саналыг бид хураалгахгүйгээр Засгийн газрын өргөн барьсан бодлогын хүрээнд бид цаашдаа хэрэгжүүлээд явах бүрэн боломжтой гэдгийг хэлье. Баярлалаа.

Х.Ганхуяг: Гишүүд ээ. Санал хураалт. /алх цохив/

6.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601000257 төслийн кодтой “Төрийн албаны шинэчлэлийн хүрээнд төрийн бүтээмжийн нэгдсэн мэдээллийн систем /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг

3,506.6 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн **1,578.0 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй.

7.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын урсгал зардал дахь Төрийн шагнал, одон, медалийн зардлыг **1,842.9 сая** төгрөгөөр буруулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал.

1.Багш, эмч нарын цалин, тэтгэврээс бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцад туссан урсгал зардлыг **0.8 хувиар** буюу **170.0 тэрбум** төгрөгөөр бууруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг тэтгэх мөнгөн тэтгэмжийн **397.5 мянган** төгрөг, Асаргааны тэтгэмжийн **302.5 мянган** төгрөг, Нийгмийн халамжийн тэтгэврийн **397.5 мянган** төгрөгийг тус тус **24 хувиар** нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, С.Эрдэнэбат. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтыг цуцалъя. Ж.Баясгалан гишүүн саналаа тайлбарлая.

Ж.Баясгалан: Гишүүд бүгд ойлгож байгаа байх. Байнга л ярьж байгаа асуудал.

302 мянган төгрөгийг 2.6 хувь нэмлээ гэхэд энэ чинь ерөөсөө 6 мянга гаруй төгрөг л нэмэгдэх гээд байна шүү дээ. Сард.

→ 30 хувь нэмээд бүгдийг нь ядаж ядуурлын түвшний доод хэмжээнд аваачъя.

→ Ядуурлаас 147 мянган хүнийг гаргая гэдэг саналыг хэлж байгаа юм.

Бид их наядаар нь яриад, тэрбумаар нь яриад 302 мянга гэдэг тоогоо бүр мартсан юм шиг байна.

Тэгвэл 302 мянган төгрөгөөр амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг шийдээд өгөөч ээ л гэж хүсэж байгаа юм. 169 тэрбум. Бидэнд

хүсэл байвал арга нь олдоно. Энэ хүмүүсийг хэдэн жилээр хойшлуулах ямар ч боломжгүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэдэг маань өнөө маргаашаа харж хүлээж байгаа тэр өвчтэй хүмүүс шүү дээ. Энэ дээр бид жилийн дараа, хоёр жилийн дараа ямар ч сайхан юм амлаад тэрийг хүрэхгүйгээр гарах олон хүн бий. Энд маш олон хүний амь нас, маш олон хүний эрх чөлөө яригдаж байгаа.

Тийм болохоор энэ асуудлыг Их Хурлын гишүүд минь бүгдээрээ дэмжээд өгөөч ээ.

Байнгын хороогоороо ороод дэмжигдсэн. Байнгын хороон дээр мэргэжлийн бүх асуулт хариулт явсан. Тийм болохлоор Та бүхнийг үүнийг дэмжээд өгөөч ээ гэж хүсэж байна. Монгол Улсад байгаа нийт өрхийн 13 хувь нь үүнийг харж байгаа шүү. Гишүүд. Бүгдээрээ дэмжээд өгөөрэй.

Х.Ганхуяг: Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй.

2027 оны төсөв дээр саяын асуудлыг бид анхаарах нь зөв өө. Ж.Баясгалан гишүүний зөв. Гэхдээ яах вэ 2026 онд яалт ч үгүй дарамттай төсөв бид батлах гэж байна.

2.Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.9 дэх “Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас” гэснийг “Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон нийгмийн даатгалын шимтгэл” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал. Санал хураалт. /алх цохив/

3.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2003400730 төслийн кодтой “Төв халх” дуулалт жүжгийн театр /Дундговь, Сайнцагаан сум/, хэрэгжих хугацаа 2011-2028 он, төсөвт өртөг **32,990.1 сая** төгрөг, санхүүжих дүн **8,671.8 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **543.7 сая** төгрөгөөр бууруулж, УТ2403100365 төслийн кодтой Спорт заалны барилга /Дундговь, Луус сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг **1,366.3 сая** төгрөг, санхүүжих дүн **255.1 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг **543.7 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат, Г.Ганбаатар.

Г.Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд. Гишүүд ээ.

Дундговь аймгийн Сайнцагаан сум, Мандалговь хотод аль 2011 онд л эхэлсэн барилга байгаа юм. “Төв халх” дуулалт жүжгийн.

Ерөнхийдөө 8 тэрбум орчим, 8.6 тэрбум орчим төгрөгийн л төсөл, арга хэмжээ л дээ. Дотроо яах вэ, сайдтай нь салбартай нь яриад энэ жилийнх нь санхүүжих санхүүжилтээс 543.7 сая төгрөгийг Дундговь аймгийн Луус суманд хэрэгжиж байгаа Спортын төв байгаа юм. Тэр лүү нь шилжүүлээд тэр арга хэмжээг нь дуусгая л гэж байгаа юм. Өөр нэг их тийм хөдөлгөөн байхгүй. Гишүүдийг бас дэмжиж өгөхийг хүсье.

Х.Ганхуяг: Санал хураалт. /алх цохив/

4.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808718 төслийн кодтой, Багануур тойрог авто зам, 14.4 км /Багануур хот/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг **43,321.9 сая** төгрөг, санхүүжих дүн **14,656.9 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **1,000.0 сая** төгрөгөөр бууруулж, төрийн өмчит Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуульд шаардлагатай урсгал зардлыг санхүүжүүлэхээр Боловсролын сайдын урсгал зардлыг **1,000.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир. Санал хураалт. /алх цохив/

Дэмжигдсэнгүй. 3.8 хувиар.

5.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зардлыг **3,199.0 сая** төгрөгөөр бууруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багц дахь Урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилтийг **3,199.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, С.Зулпхар, Д.Рэгдэл, С.Эрдэнэбат. Санал хураалт. /алх цохив/

Дэмжигдсэнгүй. 3.8 хувиар.

6.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601300966 төслийн кодтой Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцийн 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **67,119.0 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **2,000.0 сая** төгрөгөөр бууруулж, “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв”-ийн үйлдвэрлэлийн түүхий эд, материалын зардалд **1,100.0 сая** төгрөг, мөн төслийн 2 дугаар хавсралтад “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв”-ийн автомашин, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **700.0 сая** сая төгрөг”, “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв”-ийн өргөтгөлийн барилгын засвар

/Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **200.0 сая** сая төгрөг”, гэсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун. Санал хураалт. /алх цохив/

11.5 хувь дэмжсэн байна. Санал дэмжигдсэнгүй.

7.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400522 төслийн кодтой “Спорт заалын барилга /Ховд, Буянт сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **3,103.4 сая** төгрөг, санхүүжих дүн **1,396.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Санал хураалт. /алх цохив/

15.4 хувиар дэмжигдсэнгүй.

8.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400239 төслийн кодтой “Спорт заалын барилга /Хөвсгөл, Түнэл сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг **2,156.8 сая** төгрөг, санхүүжих дүн **970.6 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Санал хураалт. /алх цохив/

15.4 хувиар санал дэмжигдсэнгүй.

9.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400052 төслийн кодтой “Спорт цогцолборын барилга /Сэлэнгэ, Сайхан сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг **6,728.8 сая** төгрөг, санхүүжих дүн **2,018.7 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй. 15.4 хувиар.

10.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808719 төслийн кодтой Баруун-Урт-Бичигт чиглэлийн хатуу хучилттай авто зам /Зүүн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2028 онд, төсөвт өртөг **319,998.9 сая** төгрөг, санхүүжих дүн **23,000.0 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **5,000.0 сая** төгрөгөөр бууруулж, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг

үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын багцын урсгал зардлыг **5,000.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Санал хураалт. /алх цохив/

3.8 хувиар санал дэмжигдсэнгүй.

11.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808512 төслийн кодтой “Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 59.2 км /Хойд бүс/”, хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг **101,370.6 сая** төгрөг, санхүүжих дүн **19,710.6 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **5,000.0 сая** төгрөгөөр бууруулж Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг **5,000.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй. 7.7 хувь.

12.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808289 төслийн кодтой “Орхонтуул-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам, 62,56 км /Төвийн бүс/”, хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг **117,450.0 сая** төгрөг, санхүүжих дүн **25,000.0 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **5,000.0 сая** төгрөгөөр бууруулж Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг **5,000.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Санал хураалт. /алх цохив/

3.8 хувь. Санал дэмжигдсэнгүй.

13.Төслийн 2 дугаар хавсралтын УТ2403100360 төслийн кодтой “Спорт заалны барилга /Архангай, Эрдэнэбулган сум, Булганхангай хороолол/” хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг **1,101.0 сая** төгрөг, санхүүжих дүн **577.4 сая** төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, “Заяын Гэгээний хүрээ хийдийн цогцолборын” дээврийн засвар /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн **577.4 сая** төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй. 34.6 хувь.

Ж.Батжаргал гишүүн та түр сууж байх уу.

